

Төсөл хэрэгжүүлэгч:

“ДАМБАТ” ХХК

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ
ЦАГААНЧУЛУУТ НЭРТЭЙ ГАЗАРТ ОРШИХ MV-000400 АШИГТ
МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЛТНЫ ШОРООН
ОРДЫГ ОЛБОРЛОХ ТӨЛСИЙН БОМТ 2026**

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000400/

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2618532/

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
1.1. Ерөнхий танилцуулга	7
1.2. Төлсийн байршил.....	7
1.3. Уурхайн ажлын горим	8
1.3.1. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт	9
1.3.2. Уурхайн технологийн процессууд	10
1.3.3. Ухаж ачих ажил	11
1.3.4. Ил уурхайн тээвэр.....	14
1.3.5. Овоолго	17
1.3.6. Туслах ажил.....	21
1.4. Баяжуулах технологи.....	25
1.4.1. Угаан баяжуулах элсний тооцоо ба хүчин чадал	25
1.4.2. Элс угаан баяжуулах технологи	26
1.4.3. Технологийн ус-шлагын тооцоо.....	29
1.4.4. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ	30
1.4.5. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжүүд.....	31
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	34
2.1. Физик газарзүй	34
2.2. Цаг уур, уур амьсгал	34
2.3. Төслийн талбайн байршилд хийсэн агаарын хэмжилт судалгаа.....	35
2.4. Төслийн талбайн дуу чимээний хэмжилт судалгаа	36
2.5. Төслийн талбайн геологийн судалгаа	36
2.6. Гадаргын усны судалгаа	37
2.7. Газрын доорхи усны судалгаа.....	38
2.8. Хөрсний судалгаа.....	39
2.9. Ургамлын төрөл зүйлийн судалгаа	52
2.10. Төслийн талбайн байршилд хийгдсэн амьтны тархалт судалгаа	54
2.11. Тусгай хамгаалалттай газар.....	58
2.12. Палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлын дүгнэлт	58
2.13. Нийгэм эдийн засаг Дорнод аймгийн Баяндун сум	58
2.13.1. Дорнод аймгийн Баяндун сум.....	58

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ	60
3.1. Газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсэх.....	60
3.2. Төслөөс ургамлан нөмрөгт учруулах нөлөөлөл.....	60
3.3. Төслөөс ус орчинд учруулах нөлөөлөл.....	60
3.4. Төслөөс агаар орчинд учруулах нөлөөлөл	60
3.5. Төслөөс амьтны аймагт учруулах нөлөөлөл	61
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	62
3.6. Зорилго.....	62
3.7. Хамрах хүрээ	62
3.8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	63
3.9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	71
3.10. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 71	
3.10.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хийгдэх ажил	72
3.11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	73
3.12. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	73
3.13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	74
3.14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	77
3.15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	81
3.16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	86
3.17. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	88
3.18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал ба задаргаа.....	89
ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	90

ХҮСНЭГТИЙН ДУГААРЛАЛТ

Хүснэгт 1. MV–000400 талбайн эргэлтийн цэг.....	7
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим.....	9
Хүснэгт 3. Процессууд дахь тоног төхөөрөмжийн ажлын хугацааны хязгаарын үзүүлэлт9	
Хүснэгт 4. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө.....	9
Хүснэгт 5. Ил уурхайн элс, металл олборлолт	10

Хүснэгт 6. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл	11
Хүснэгт 7. Экскаваторын техникийн үзүүлэлт	11
Хүснэгт 8. Экскаваторын бүтээлийн тооцоо.....	12
Хүснэгт 9. Шаардлагатай экскаваторын тоо, ажиллах цаг.....	13
Хүснэгт 10. Шаардлагатай экскаваторын тоо, ажиллах цаг.....	14
Хүснэгт 11. Автосамосвалын техникийн үзүүлэлт	14
Хүснэгт 12. Бульдозерын техникийн үзүүлэлт.....	17
Хүснэгт 13. Овоолгын бульдозерийн бүтээлийн тооцоо	19
Хүснэгт 14. Бульдозерын бүтээл, шаардлагатай тоо.....	21
Хүснэгт 15. Зам усалгаа	21
Хүснэгт 16. Усны машины техникийн үзүүлэлт	22
Хүснэгт 17. Шаардлагатай усны машины тоо	22
Хүснэгт 18. Түлшний машины техникийн үзүүлэлт	23
Хүснэгт 19. Тоног төхөөрөмжүүдийн түлш зарцуулалт.....	23
Хүснэгт 20. Тоног төхөөрөмжийн жагсаалт	24
Хүснэгт 21. Баяжуулах элсний хэмжээ.....	25
Хүснэгт 22. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	25
Хүснэгт 23. Элс угаан баяжуулах технологийн тоо-чанарын нэгдсэн тооцоо	28
Хүснэгт 24. Баяжуулах технологийн тоо-чанарын схем.....	29
Хүснэгт 25. Элс угаан баяжуулах технологийн ус-шлагын нэгдсэн тооцоо	30
Хүснэгт 26. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо	31
Хүснэгт 27. Угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлт.....	32
Хүснэгт 28. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлт.....	32
Хүснэгт 29. Технологийн ус шахах насосны техникийн үзүүлэлт	32
Хүснэгт 30. Угаан баяжуулах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт	33
Хүснэгт 31. Төслийн талбайн агаарын чанарын төлөв байдал (Ажиллаж байх хугацааных), (20 мин сорьц)	35
Хүснэгт 32. Дуу чимээний хэмжилтийн үр дүн.....	36
Хүснэгт 33. Цагаанчулуут худаг талбай дахь тогтоол устай нуурын шинжилгээний хариу	39
Хүснэгт 34. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-1.....	41
Хүснэгт 35. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/.....	41
Хүснэгт 36. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/	42
Хүснэгт 37. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-2.....	42
Хүснэгт 38. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/.....	43
Хүснэгт 39. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/	43

Хүснэгт 40. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-3.....	44
Хүснэгт 41. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-1.....	45
Хүснэгт 42. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-2.....	45
Хүснэгт 43. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-3.....	45
Хүснэгт 44. Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт.....	46
Хүснэгт 45. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-4.....	47
Хүснэгт 46. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/.....	48
Хүснэгт 47. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/.....	48
Хүснэгт 48. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/.....	48
Хүснэгт 49. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-5.....	49
Хүснэгт 50. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/.....	50
Хүснэгт 51. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/.....	50
Хүснэгт 52. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/.....	50
Хүснэгт 53. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-6.....	51
Хүснэгт 54. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-7.....	51
Хүснэгт 55. Байгалийн фон буюу эрүүл талбай, ургамлын бичиглэл судалгаа-1.....	52
Хүснэгт 56. Нөхөн сэргээлт хийгдсэн талбай, ургамлын бичиглэл, судалгаа-2.....	53
Хүснэгт 57. Ургамлын бичиглэл судалгаа-3.....	54
Хүснэгт 58. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-1.....	55
Хүснэгт 59. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-2.....	55
Хүснэгт 60. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-3.....	55
Хүснэгт 61. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-4.....	56
Хүснэгт 62. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-5.....	56
Хүснэгт 63. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-6.....	56
Хүснэгт 64. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-7.....	57
Хүснэгт 65. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-8.....	57
Хүснэгт 66. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-9.....	57
Хүснэгт 67. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-10.....	58
Хүснэгт 68. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	63
Хүснэгт 69. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	72
Хүснэгт 70. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ба түүний зардал.....	74
Хүснэгт 71. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	78
Хүснэгт 72. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	83
Хүснэгт 73. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	86

Хүснэгт 74. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	88
Хүснэгт 75. Нийт байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	89

ЗУРГИЙН ДУГААРЛАЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил	8
Зураг 2. Авто замын хөндлөн огтлол (а. траншейн б.овоолгын)	15
Зураг 3. Авто замын бүдүүвч.....	15
Зураг 4. Бульдозерийн овоолгын схем.....	18
Зураг 5. Угаан баяжуулах технологийн схем.....	27
Зураг 6. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем.....	31
Зураг 7. Төслийн талбайн байршилтай хамгийн ойр байрлах голын сүлжээ	38
Зураг 8. Төслийн үйл ажиллагаа явуулах талбайн байршил хөрсний бүлгээр.....	40

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Ерөнхий танилцуулга


1. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Дамбат” ХХК
2. Улсын бүртгэлийн дугаар: 9011154073
3. Регистрийн дугаар: 2618532
4. Хаяг: Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Бакуларембүчигийн гудамж, 30-р байр, 801 тоот
5. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-000400
6. Үйл ажиллагаа явуулах газрын нэр: Цагаан чулуут худаг (Алтны шороон орд ашиглах төсөл)

1.2.Төлсийн байршил

MV-000400 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан чулуут худаг” алтны шороон ордын талбай нь Дорнод аймгийн Баяндун суманд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн зүгт 650 км, аймгийн төв Чойбалсан хотоос чанх хойш 200 км, сумын төв Баяндунгаас зүүн хойш 30 км, Дашбалбар сумаас баруун зүг 80 км-т байрлана.

Хүснэгт 1. MV-000400талбайн эргэлтийн цэг

Цэгийн дугаар	Газарзүйн солбицол						Тэгш өнцөгтийн солбицол	
	УРТРАГ			ӨРГӨРӨГ			Ү	Х
1	113°	25'	10.63"	49°	28'	52.52"	675257.633	5483770.860
2	113°	24'	46.31"	49°	28'	53.02"	674767.866	5483770.604
3	113°	24'	45.81"	49°	28'	43.32"	674767.400	5483470.769
4	113°	24'	44.33"	49°	28'	43.35"	674737.594	5483470.742
5	113°	24'	43.05"	49°	28'	17.16"	674737.734	5482661.234
6	113°	24'	52.47"	49°	28'	16.97"	674927.472	5482661.440
7	113°	24'	51.69"	49°	28'	1.12"	674927.461	5482171.528
8	113°	24'	58.14"	49°	28'	0.98"	675057.399	5482171.366
9	113°	24'	57.18"	49°	27'	41.58"	675057.288	5481571.723
10	113°	25'	16.53"	49°	27'	41.17"	675447.137	5481571.564
11	113°	25'	17.49"	49°	28'	0.58"	675447.196	5482171.517
12	113°	25'	12.03"	49°	28'	0.7"	675337.199	5482171.692
13	113°	25'	12.81"	49°	28'	16.54"	675337.184	5482661.295
14	113°	25'	10.83"	49°	28'	16.58"	675297.302	5482661.251
15	113°	25'	12.14"	49°	28'	42.77"	675297.683	5483470.780
16	113°	25'	10.15"	49°	28'	42.81"	675257.607	5483470.729
Ордын төв цэг	113°	24'	59.81"	49°	28'	21.32"	675070.861	5482800.493



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.3. Уурхайн ажлын горим

Цагаан чулуут худгийн уурхай нь 2026 оны 5-р сараас 10-р сарын хооронд ажиллах бөгөөд жилд ажиллах боломжит 178 хоногоос Уурхайн ажиллах хоног 129 хоног гэж төлөвлөж дараах хугацааг хорогдуулан уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг тооцлоо. Үүнд:

- Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасны дагуу амралтын 7 хоног байгаагаас Улсын баяр, наадмаар 5 хоног амрах бөгөөд бусад өдрүүдэд амрахгүй байхаар тооцсон;
- Цаг агаарын саатал 14 хоногийг хасаж тооцсоноор уурхайн жилд ажиллах цэвэр хугацааг 159 хоног байхаар тооцлоо.

Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байх бөгөөд цайны цаг, ээлжийн бэлтгэл төгсгөл цаг зэргийг хасаж тооцсоноор ээлжид ажиллах цэвэр хугацаа 10 цаг байхаар тооцлоо. Уурхайн ээлжийн цаг ашиглалтын коэффициент 0.83, жилд 3180 цаг ажиллах хязгаартай байна.

Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Х.нэгж	Хэмжээ
1	Жилд ажиллах боломжит хугацаа	хоног	178
2	Жилд амрах баяр ёслолын өдрүүд	хоног	5
3	Цаг агаарын саатал	хоног	14
4	Жилд ажиллах хугацаа	хоног	129
5	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
7	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент		0.83
8	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	318
9	Жилд ажиллах цаг	цаг/жил	3,180

Ил уурхайн технологийн процесс ба тоног төхөөрөмжийн ажлын горим:

Ил уурхайн үйлдвэрлэлийн процессыг хэрэгжүүлэх ба тоног төхөөрөмжийн ажиллагаанд мөрдөх ажлын горимын төслийн шийдлийг хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгт 3. Процессууд дахь тоног төхөөрөмжийн ажлын хугацааны хязгаарын үзүүлэлт

№	Процессууд	Тоног төхөөрөмж	Үндсэн үйлдвэрлэлд зориулах цаг хугацааны хязгаар					Хорогдох хугацаа, хоног
			Ээлжинд, цаг	Хоногт, цаг	Жилд			
		хоног			ээлж	цаг		
1	Экскаваци	Экскаватор	10	20	159	318	3,180	Амралт 5 хоног; 14 цаг агаарын саатал
2	Тээвэр	Автосамосвал	10	20	159	318	3180	
3	Овоолго	Бульдозер	10	20	159	318	3180	

1.3.1. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт

2026 он уулын ажлын талбайн хойд хэсгээс буюу бага гүнтэй нөөцөөс эхлэн 110.79 мян.м3 элс олборлон угаан баяжуулахаар тооцлоо. Уурхайн хөрс хуулалтын дундаж коэффициент ордын дунджаар $K_{хд}=5.5$ м3/м3 байна.

Хүснэгт 4. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт	Элс олборлолт	Бохирдол		Үйлдвэрлэлийн элс	Хөрс хуулалтын коэффициент
Х.нэгж	мян.м ³	мян.м ³	%	мян.м ³	мян.м ³	м ³ /м ³
2026 онд	551.1	97.49	29.4	28.79	126.22	4.3

Хүснэгт 5. Ил уурхайн элс, металл олборлолт

Металл	Геологийн нөөц				Ашиглалтын хаягдал		Үйлдвэрлэлийн нөөц			
	Дундаж агуулга		Металлын (эрдэс) нөөц		Хаягдал металл (эрдэс)		Дундаж агуулга		Металлын (эрдэс) нөөц	
	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга
34	35	36	37	38	39	40	41	42	43	44
Алт (Au)	г/м3	0.39	кг	4.62	кг	0.00	г/м3	0.30	кг	4.62
Алт (Au)	г/м3	0.38	кг	3.14	кг	0.00	г/м3	0.29	кг	3.14
Алт (Au)	г/м3	0.22	кг	2.12	кг	0.00	г/м3	0.17	кг	2.12
Алт (Au)	г/м3	0.43	кг	3.21	кг	0.00	г/м3	0.33	кг	3.21
Алт (Au)	г/м3	0.72	кг	3.48	кг	0.00	г/м3	0.57	кг	3.48
Алт (Au)	г/м3	0.21	кг	0.59	кг	0.00	г/м3	0.13	кг	0.59
Алт (Au)	г/м3	0.20	кг	5.53	кг	0.00	г/м3	0.16	кг	5.53
Алт (Au)	г/м3	0.36	кг	0.38	кг	0.00	г/м3	0.24	кг	0.38
Алт (Au)	г/м3	0.40	кг	0.07	кг	0.00	г/м3	0.20	кг	0.07
Алт (Au)	г/м3	0.18	кг	0.27	кг	0.00	г/м3	0.11	кг	0.27
Алт (Au)	г/м3	0.17	кг	1.83	кг	0.00	г/м3	0.13	кг	1.83
							---		---	
							---		---	
							---		---	
		0.00		0.00		0.00		0.00		0.00
		0.36		22.69		0.00		1.94		22.69
		1.12		2.55		0.00		0.69		2.55
				25.24		0.00		0.20		25.24

Бохирдолт				Ашиглалтын хаягдал				Үйлдвэрлэлийн нөөц					
Бохирдолтын хувь		Бохирдуулагч чулуулаг		Хаягдлын хувь		Хаягдал хүдэр (элс)		Нэмэгдэх хөрсний нөөц		Нийт хөрс хуулалт		Хүдрийн (элс) нөөц	
Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга
19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32
%	29.60	мян.м3	4.00	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	118.50	мян.м3	17.496
%	29.50	мян.м3	2.83	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	73.44	мян.м3	12.432
%	33.90	мян.м3	3.69	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	115.20	мян.м3	14.56832
%	27.90	мян.м3	2.39	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	81.12	мян.м3	10.97382
%	27.30	мян.м3	1.49	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	56.42	мян.м3	6.95058
%	65.60	мян.м3	2.05	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	21.62	мян.м3	5.179968
%	21.50	мян.м3	6.69	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	36.29	мян.м3	37.79136
%	50.00	мян.м3	0.59	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	22.88	мян.м3	1.755
%	58.80	мян.м3	0.12	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	4.70	мян.м3	0.3176
%	30.90	мян.м3	0.51	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	7.81	мян.м3	2.15985
%	35.80	мян.м3	4.37	%		мян.м3	0	мян.м3		мян.м3	13.12	мян.м3	16.592044
												мян.м3	
												мян.м3	
												мян.м3	
	0.00		0.00		0.00		0.00		0.00		0.00		0.00
	28.13		23.14		0.00		0.00		0.00		502.59		105.39
	36.66		5.59		0.00		0.00		0.00		48.51		20.82
	29.47		28.73		0.00		0.00		0.00		551.10		126.22

1.3.2. Уурхайн технологийн процессууд

Ил уурхайн үйл ажиллагаа нь хөрс, элсийг ухаж ачин, тээвэрлэн овоолгод овоолох гэсэн үндсэн процессоор явагдана. Шимт хөрс хуулалтын ажил хийхгүй байхаар тооцлоо. Учир нь нөөцийн тодотгол хийсэн хэсэгшлүүд өмнөх онуудад ашиглалтад өртөн дотоод овоолго овоолсон тул шимт хөрс гэх зүйлгүй байна.



Хүснэгт 6. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
	Олборлолт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох (агуулахад хураах)

1.3.3. Ухаж ачих ажил

Цагаан чулуут хурдгийн ил уурхайд “Liugong 970E” маркын 4.2 м³ утгуурын багтаамжтай 1 ш экскаватор, Hyundai R520LC” маркын 3.2 м³ утгуурын багтаамжтай 1 ш экскаватор хөрс хуулалт, элс олборлолтод ажиллахаар тооцлоо.

Хүснэгт 7. Экскаваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Х.нэгж	Liugong 970E	Hyundai R520LC	Зураг	
1	Утгуурын багтаамж	м ³	4.2	3.2		
2	Сумны урт	м	6.6	6.3		
3	Гарны урт	м	2.9	2.4		
4	Утгалтын түвшин дэх хамгийн их радиус	м	11.2	10.3		
5	Утгалтын хамгийн их өндөр	м	10.95	9.5		
6	Утгалтын хамгийн их гүн	м	7.18	6.26		
7	Ачилтын хамгийн их өндөр	м	7	6.65		
8	Арын эргэлтийн радиус	м	4.9	4.74		
9	Хөдөлгүүрийн чадал	кВт	391	257		
10	Явах хурд	км/цаг	2.7-4.4	3.1-5.4		
11	Жин	т	70.5	50.8		
12	Түлшний савны багтаамж	л	685	685		
13	Явах ангийн үндсэн хэмжээсүүд					
13.1	Урт	м	5.99	5.45		
13.2	Гадна өргөн	м	4.0	3.34		
13.3	Өндөр	м	1.49	1.21		

Экскаваторын бүтээлийн тооцоог (4.4.1-1, 2) томъёогоор тооцлоо.

Экскаваторын цагийн бүтээл (м³/цаг):

$$Q_{эц} = \frac{3600 \cdot E \cdot K_{уд} \cdot K_m \cdot K_{эт} \cdot K_{ха} \cdot K_{уч}}{t_{эм} \cdot K_c}; \quad (4.4.1 - 1)$$

Үүнд:

E – утгуурын багтаамж, м3;

$K_{уд}$ – утгуур дүүргэлтийн коэффициент;

$K_{м}$ – мөргөцгийн нөхцөл тооцох коэффициент;

$K_{эт}$ – экскаваторын төрлийг тооцох коэффициент;

$K_{ха}$ – хаягдал тооцох коэффициент;

$K_{уч}$ – операторын ур чадвар тооцох коэффициент;

$t_{эм}$ – мөчлөгийн хугацаа, сек;

K_c – сийрэгжилтийн коэффициент;

Экскаваторын ээлжийн бүтээл (м3/ээлж):

$$Q_{ээ} = Q_{эц} \cdot T_э \cdot K_{эц} \cdot K_{ма} \cdot K_{тх}; \quad (4.4.1 - 2)$$

Үүнд:

$T_э$ – ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг;

$K_{эц}$ – ээлжийн цаг ашиглалтын коэффициент;

$K_{ма}$ – мөргөцөг дэх ахилт шилжилтийг тооцох коэффициент;

$K_{тх}$ – экскаваторыг тээврээр хангах нөхцөлийг тооцох коэффициент;

Хүснэгт 8. Экскаваторын бүтээлийн тооцоо

№	Тэм	Үзүүлэлт	Х.н	Liugong 970E	Hyundai R520LC
1		Экскаваторын ажлын мөргөцөг		Хөрс	Элс
2	Аор	Экскаваторын орлын өргөн	м	17.9	17.9
3	Рут	Утгалтын түвшин дэх радиус	м	11.2	10.3
4	E	Утгуурын багтаамж	м3	4.2	3.2
5	Куд	Экскаваторын утгуур дүүргэлтийн коэффициент		0.95	1.0
6	Км	Мөргөцгийн нөхцөлийг тооцох коэффициент	-	0.9	0.9
7	Кэт	Экскаваторын төрлийг тооцох коэффициент	-	1.0	0.9
8	Кха	Хаягдал тооцох коэффициент	-	0.9	0.9
9	Куч	Экскаваторын операторын ур чадвар тооцох коэффициент	-	0.9	0.9
10	тм	Мөчлөгийн хугацаа	сек	30	30

11	Кс	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.25	1.1
12	Qэц	Экскаваторын цагийн бүтээл	м3	279.2	229.0
13	Тэ	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
14	Кэц	Экскаваторын ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.83	0.83
15	Кма	Мөргөцөг дэх ахилт шилжилт тооцох коэффициент	-	0.95	0.95
16	Ктх	Тээврээр хангах нөхцөлийг тооцох коэффициент	-	0.9	0.85
17	Qээ	Экскаваторын ээлжийн бүтээл	м3	2,377.9	1,842.1
18	пээ	Хоногт ажиллах ээлжийн тоо	ш	2	2
19	Qэх	Экскаваторын хоногийн бүтээл	м3	4,755.8	3,684.2
20	Нэж	Ажиллах хоног	хоног	159	129
21	Кб	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент		0.85	0.85
22	Qэж	Экскаваторын жилийн бүтээл	м3	642,752	403,970

Уулын ажилд шаардлагатай экскаваторын тооцоог техникийн бүтээлээр (4.4.1-3) томъёог ашиглан тооцлоо.

Шаардлагатай экскаваторын тоо:

$$N_d = \frac{Q_{у.ж}}{Q_{д.ж}}; \quad (4.4.1 - 3)$$

Үүнд:

$Q_{ж}$ – жилийн уулын ажлын хэмжээ; м3

$Q_{эж}$ – техникийн жилийн бүтээл; м3/жил

Хүснэгт 9. Шаардлагатай экскаваторын тоо, ажиллах цаг

Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт	Экскаваторын бүтээл		Экскаваторын тоо (тооцооны)	Шаардлагатай экскаваторын тоо (бодит)	НЭгж экскаваторын ажиллах цаг
		мян.м3/жил	м3/цаг			
Х.нэгж	мян.м3	мян.м3/жил	м3/цаг	ш	ш	мото.ц
1 дэх жил	663.1	642.8	279.2	1.0	1	2,374.7

Хүснэгт 10. Шаардлагатай экскаваторын тоо, ажиллах цаг

Ашиглалтын жилүүд	Элс олборлолт	Экскаваторын бүтээл		Экскаваторын тоо (тооцооны)	Шаардлагатай экскаваторын тоо (бодит)	Экскаваторын ажиллах цаг
		мян.м3/жил	м3/цаг			
Х.нэгж	мян.м3	мян.м3/жил	м3/цаг	ш	ш	мото.ц
1 дэх жил	120.0	404.0	229.0	0.3	1	523.9


Уулын ажилд шаардлагатай экскаваторын тоог бүтээлийг хангах нөхцөлөөр тооцож үзэхэд хөрс хуулалтанд 0.8-1.2 ш, олборлолтод 0.3 ш буюу уулын цулаар 2 ш экскаватор ажиллахад техникийн бүтээл ордын хөрс хуулалт, ашигт малтмал (сийрэгжилт тооцсон) олборлоход хүчин чадал, нөөцийн хувьд бүрэн хүрэлцээтэй байна.


1.3.4. *Ил уурхайн тээвэр*

Ил уурхайн дотоод тээврийн автосамосвалууд нь шимт хөрс болон хөрс, ашигт малтмалыг (элс) уурхайн үйлдвэрлэлийн замаар тээвэрлэж хөрсийг хөрсний гадаад, дотоод овоолгод, ашигт малтмалыг элс угаах хэсгийн түр агуулах (түр овоолго) хүртэл тээвэрлэнэ.

Уурхайн дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн “Tonly TL875B” маркийн автосамосвал ашиглахаар тооцож ил уурхайн тээврийн тооцоог хийлээ.


Хүснэгт 11. Автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.н	Утга	Зураг
1	Автосамосвалын марк	-	Tonly TL875B	
2	Даац	т	60	
3	Өөрийн жин	т	30	
4	Тэвшний багтаамж	м3	30	
5	Дээд хурд	км/цаг	40	
	Дундаж хурд	км/цаг		
6	Зүтгэх хамгийн их налуу	град	17.74	
		0/0	32	
		0/00	320	
7	Хөдөлгүүрийн заасан чадал	кВт	358	
		мор/хүч	480	
8	Автосамосвалын тэвшний хэмжээс			
8.1	Урт	м	5.4	
8.2	Өргөн /гадна/	м	3.1	
8.3	Өндөр	м	1.8	
9	Автосамосвалын хэмжээс			
9.1	Урт	м	9.1	
9.2	Өргөн	м	3.5	
9.3	Өндөр	м	4.1	
10	Дугуйн томъёо	-	6x4	
11	Дугуйн хэмжээ	-	14.00R-25	
12	Түлшний савны багтаамж	л	500	
13	Дугуйн тоо	ш	10	



Зураг 2. Авто замын хөндлөн огтлол (а. траншейн б.овоолгын)

Ил уурхайн технологийн авто замын төлөвлөлт: Цагаан чулуут худгийн ил уурхайн хөрсийг уурхайн зүүн хойд тал байрлах хөрсний гадаад овоолго болон дотоод овоолгод, элсийг уурхайн ШГ-89-92 хооронд байрлах элс угаах хэсгийн овоолгод буулгана.



Зураг 3. Авто замын бүдүүвч

а. Хөрсний гадаад овоолго, б. Хөрсний дотоод овоолго, элс тээвэр

Автосамосвалын бүтээлийн тооцоог $\frac{\gamma}{K_c} < \frac{q}{V}$ нөхцөлөөр шалган тэвш ашиглалтын нөхцөлөөр тооцов.

Автосамосвалын рейсийн хугацаа (сек):

$$T_p = t_a + t_{x\theta} + t_6 + t_{c3} + t_3; \quad (4.4.2 - 3)$$

Үүнд:

$$t_a = \frac{V_a \cdot K_o \cdot t_m}{K_{уд} \cdot E} - \text{автосамосвалыг ачаалах хугацаа, мин};$$

V_a – автосамтосвалын тэвшний багтаамж, м³;

K_o – овоолцыг тооцох коэффициент, ($K_o = 1.1 - 1.15$)

t_m – экскаваторын мөчлөгийн хугацаа, сек;

$K_{уд}$ – экскаваторын утгуур дүүргэлтийн коэффициент;

$t_{хө} = k_x \cdot \sum t$ – автосамосвалын хөдөлгөөний хугацаа, мин

$k_x = 1.1$ – хурд өөрчлөлтийг тооцсон коэффициент;

$\sum t$ – хэсэг тус бүрээр ачаатай ба хоосон чиглэлд явах хугацааны нийлбэр, мин;

t_6 – ачаа буулгах хугацаа, мин (0.75-1.5 мин)

$t_{сэ} = t_a + t_6$ – сэлгээ хийх хугацаа, мин

t_a – ачих үед сэлгээ хийх хугацаа, мин

t_6 – буулгах үед сэлгээ хийх хугацаа, мин

t_3 – 1-2 мин, ачих, буулгах үеийн хэлээх хугацаа, 1 мин;

Автосамосвалын ээлжийн бүтээл тэвш ашиглалтын нөхцөлөөр (м³/ээлж):

$$Q_{аэ} = 60 \cdot V_a \cdot K_d \cdot \frac{T_э \cdot K_{ц}}{T_p}; \quad (4.4.2 - 4)$$

Үүнд:

V_a – автосамтосвалын тэвшний багтаамж, м³;

K_d – автосамосвалын тэвш ашиглалтын коэффициент;

$T_э$ - ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг;

$K_{ц}$ – автосамосвалын ээлжийн цаг ашиглалтын коэффициент;

T_p - Рейсийн хугацаа, мин

Автосамосвалын жилийн бүтээл техникийн бэлэн байдлын коэффициентээр:

$$Q_{аж} = Q_a \cdot n_a \cdot (T_y \cdot K_{б.б} - T_{т.з}); \quad (4.4.2 - 5)$$

Үүнд:

n_a – ээлжийн тоо;

T_y – уурхайн жилд ажиллах хоног;

$K_{б.б} = \frac{T_a}{T_a + T_{у.з}}$ – автосамосвалын техникийн бэлэн байдлын коэффициент;

$T_a = T_y - T_{т.з} - T_{у.з}$ - автосамосвалын жилд ажиллах хоног;

$T_{т.з}$ – төлөвлөгөөт засварын хугацаа, 7 хоног

$T_{у.з}$ – урсгал засварын хугацаа


1.3.5. Овоолго

Хөрсний гадаад овоолгод “CAT-D9” маркийн бульдозер ажиллана. Уурхайн жил бүрийн уулын ажлын хэмжээнээс хамааруулж хуулах хөрсний хэмжээг сийрэгжилт тооцсоноор тооцсон.

Ил уурхайн овоолгын бульдозерын техникийн үзүүлэлтүүдийг хүснэгт 12-д харууллаа.

Хүснэгт 12. Бульдозерын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.нэгж	CATD9	Зураг
1	Хусуурын төрөл	-	9SU	
2	Хөдөлгүүрийн чадал	кВт	337	
3	Жин	т	50	
4	Хусуурын хамах чадвар	м3	13.5	
5	Хусуурын өргөн	м	4.7	
6	Хусуурын өндөр	м	1.9	
7	Өргөлт, буулгалт	м	1.4	
8	Ухах гүн	м	0.6	
9	Хөдөлгөөний хурд, хоосон чиглэлд	м/сек	1.8	
10	Хөдөлгөөний хурд, ачаатай чиглэлд	м/сек	1.2	
11	Шатахууны савны багтаамж	л	963	
12	Бульдозерын өргөн	м	-	
13	Бульдозерын урт	м	6.6	
14	Бульдозерын өндөр	м	3.82	



Зураг 4. Бульдозерийн овоолгын схем

Овоолгын бульдозерийн бүтээлийн тооцоог (4.4.3–1, 2) томъёогоор тооцож хүснэгт 13-д үзүүлэв.

Овоолгын бульдозерийн цагийн бүтээл (м3/цаг):

$$Q_{\text{дц}} = \frac{3600}{t_{\text{м}}} \cdot V_{\text{ут}} \cdot K_{\text{тт}} \cdot K_{\text{сэ}} \cdot K_{\text{х}}; \quad (4.4.3 - 1)$$

Үүнд:

$t_{\text{м}}$ – мөчлөгийн хугацаа, сек

$S_{\text{тл}}$ – утгуурын багтаамж, м3

$K_{\text{тт}}$ – түрэлт ашиглалтын коэффициент

$K_{\text{сэ}}$ – сэлгээг тооцох коэффициент

$K_{\text{х}}$ – хаягдал тооцох коэффициент

Овоолгын бульдозерийн ээлжийн бүтээл (м3/ээлж):

$$Q_{\text{бц}} = Q_{\text{дц}} \cdot T \cdot K_{\text{ца}} \cdot K_{\text{шх}}; \quad (4.4.3 - 2)$$

Үүнд:

T – ээлжийн үргэлжилэх хугацаа

$K_{\text{ца}}$ – цаг ашиглалтын коэффициент

$K_{\text{шх}}$ – шилжилт хөдөлгөөнийг тооцох коэффициент

Хүснэгт 13. Овоолгын бульдозерийн бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлт	Тэм	Х.нэгж	Дундаж
1	Уурхайн хөрс хуулалтын цагийн ажлын хэмжээ		м3/цаг	399.8
2	Уурхайн ажиллагааны жигд бусыг тооцох коэффициент			1.2
3	Автосамосвалын нэг рейсэнд тээвэрлэх хөрсний эзлэхүүн		м3	26.1
4	Автосамосвалын тэвшин дэх чулуулгийн сийрэгжилт			1.15
5	Чулуулгийн эзлэхүүн жин		т/м3	1.4
6	Автосамосвалын тэвшний эзлэхүүн		м3	30
7	Нэг цагийн турш овоолго дээр ачаа буулгах автосамосвалын тоо		ш	18.4
8	Овоолго дээр нэгэн зэрэг буулгалт хийх автосамосвалын тооцооны тоо	Наз	ш	0.6
9	Автосамосвал ачаа буулгах, сэлгээ хийх хугацаа		сек	2.0
10	Овоолго дээр нэгэн зэрэг буулгалт хийх автосамосвалын тоо		ш	1
11	Сэлгээ хийхэд шаардагдах овоолгын фронтын дагуух урт		м	20

12	Автосамосвал ачаагаа саадгүй буулгахад шаардагдах хэсгийн урт	Lбх	м	20
13	Овоолго дээр буулгалт хийх хэсгийн тоо	Ноб	ш	1
14	Овоолго дээрх нөөц хэсгийн тоо	Нон	ш	1
15	Овоолго дээр тэгшлэлт хийх хэсгийн тоо	Нот	ш	1
16	Овоолго дээрх хэсгүүдийн нийт тоо	Нов	ш	3
17	Овоолгын фронтын нийлбэр урт	Лоф	м	60
18	Асгацын хөндлөн огтлолын талбай	Sac	м ²	7.5
19	Овоолгын тогтвортой өнцөг, 30 град		град	1.73
20	Овоолгын хажуугийн өнцөг, 35 град		град	1.43
21	Үлдэц асгацын хөндлөн огтлолын талбай	S'ac	м ²	7.91
22	Асгацын өндөр	hac	м	1.95
23	Овоолго дээр асгалтын дараа үлдэх үлдэц	Ky	%	10.6
24	Овоолгын өндөр		м	16
25	Овоолгын бульдозерийн цагийн ажлын хэмжээ	Vaц	м ³ /цаг	42.4
26	Түрэх призмийн хөндлөн огтлолын талбай	Стп	м ²	2.8
27	Хусуурын өндөр	hx	м	1.9
28	Хусуурын урт	lx	м	4.7
29	Түрэлт хийх тоо	пт	ш	1
30	Түрэлт ашиглалтын коэффициент	Ктт		2.8
31	Сэлгээг тооцох коэффициент	Ксэ		0.9
32	Хаягдал тооцох коэффициент	Кх		0.96
33	Мөчлөгийн хугацаа	tm	мин	4
34	Овоолгын бульдозерын цагийн бүтээл	Qцаг	м ³ /цаг	481.8
35	Ээлжийн үргэлжлэх хугацаа	T	цаг	12.0
36	Бульдозерын цаг ашиглалтын коэффициент	Кба		0.83
37	Бульдозерын шилжилт хөдөлгөөнийг тооцох коэффициент	Кбш		0.9
38	Овоолгын бульдозерын ээлжийн бүтээл	Qээлж	м ³ /ээлж	4,319.1
39	Овоолгын бульдозерын хоногийн бүтээл	Qхоног	м ³ /хоног	8,638.2
40	Овоолгын бульдозерын жилийн бүтээл	Qжил	м ³ /жил	1,373,480.1

Хүснэгт 14. Бульдозерын бүтээл, шаардлагатай тоо

Ашиглалтын жилүүд	Овоолго дээр бульдозероор гүйцэтгэх ээлжийн ажлын хэмжээ	Бульдозерын ээлжийн бүтээл	Шаардлагатай бульдозерын тоо /тооцооны/	Нөөцийн итгэлцүүр тооцсон, 1.2	Шаардлагатай бульдозерын тоо /бодит/	Жилд ажиллах цаг
Х.нэгж	м3/ээлж	м3/ээлж	ш	ш	ш	мото.цаг
1 дэх жил	203.0	1,972.8	0.10	0.1	1	153.4

Тооцоогоор ашиглалтын хугацаанд овоолго дээр 1 ширхэг бульдозер ажиллахад жил бүрийн хөрсний овоолгын ажлыг бүрэн хангахуйц бүтээлтэй байна.

1.3.6. Туслах ажил

Туслах ажлууд болох суваг шуудуу татах болон зам талбайг тэгшлэх ажилд уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд “Hyundai R520LC” маркын экскаватор, “Liugong ZL50” маркийн дугуйт ачигч, “Cat D9” маркын бульдозерууд ажиллана. Түлш, усны автоцистерн болон бусад тоног төхөөрөмж болох суудлын машин, хангамжийн машин зэргийг худалдаж авч ашиглахаар тооцлоо.

Замын ашиглалт, үйлчилгээ: Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, хальтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр элс цацах, замыг бороо, үерээс хамгаалах зэрэг ажлууд орно.

Замын тохижилт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс замын тоосжилтыг дарах ажлыг хийж байх шаардлагатай. Төсөлд замын тоосжилтыг усаар дарахаар тооцсон. Замын хучилтын арчилгаа хийх хугацаа, материалын зарцуулалтыг хүснэгт 15-д харуулав.

Хүснэгт 15. Зам усалгаа

Тоос дарах материал	Материалын зарцуулалт	Усалгааны давтамж	Тайлбар
Ус: ердийн хучилттай зам	0.5 л/м	1-4 цаг	Их халуун нөхцөлд усны зарцуулалтыг 2 дахин нэмнэ

Эх сурвалж. Б.Пүрэвтогтох. Ил уурхайн тээвэр. УБ. 2018 он. Хууд.56, Хүснэгт 2.20

Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв цаг агаар, хөдөлгөөний эрчмийн байдлаас шалтгаалан тоосжилт ихэсвэл замын тоос дарах ажиллагааг дахин давтана. Замын тоос дарах, унд ахуйн хэрэглээний ус хангамжинд “Dongfeng” үйлдвэрийн “EQ1060” загварын усны машин ажиллана.

Хүснэгт 16. Усны машины техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.н	Утга
1	Загвар		Dongfeng EQ1060
2	Өөрийн жин	т	6.5
3	Усны савны багтаамж	м ³	3000
4	Усны машины бүтээл	м ³ /ца г	30
5	Дээд хурд	км/ца г	90
6	Хөдөлгүүрийн заасан чадал	кВт	198
7	Овор хэмжээ		
8	Урт	м	7.9
9	Өргөн	м	2.5
10	Өндөр	м	3.1
11	Дугуйн томъёо	-	4x2
12	Дугуйн хэмжээ	-	12 R22.5
13	Түлшний төрөл		Дизель
14	Түлшний савны багтаамж	л	400
15	Дугуйн тоо	ш	10



Ил уурхайн зам услах, замын тоос дарах ажиллагаанд шаардагдах усны машины тоог ОХУ-д хэрэглэдэг аргачлалын дагуу тооцов. Шаардлагатай усны машины тоог дараах томъёогоор тооцов.

$$N_{y.m} = \frac{1.25 \cdot L_3 \cdot B_3 \cdot q_{yc} \cdot n_y}{Q_{y.m}}; \text{ ш} \quad (4.4.4 - 1)$$

L_3 – замын урт, м

B_3 – замын өргөн, м

q_{yc} – усны зарцуулалт, м³/м²

n_y – 1 цагт услах тоо

$Q_{y.m}$ – усны машины бүтээл, м³/цаг

Хүснэгт 17. Шаардлагатай усны машины тоо

№	Үзүүлэлт	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил
1	Замын урт, км	2.4	3.3	1.5
2	Замын өргөн, м	10	10	10
3	Усны зарцуулалт, м ³ /м	0.002	0.002	0.002
4	1 цагт услах тоо	0.25	0.25	0.25
5	Усны машины бүтээл, м ³ /цаг	60	60	60
6	Шаардлагатай машины тоо	0.3	0.3	0.2

Тоног төхөөрөмжийг түлшээр хангах: Түлшийг гэрээт компани уурхай дээр тээвэрлэн авч ирнэ. Уурхайн ШТС буюу түлшний агуулах нь шахуурга болон шүүлтүүртэй баригдсан, хэвийн ашиглаж байна.

Хүснэгт 18. Түлшний машины техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.н	Утга
1	Загвар		Dongfeng 5CBM
2	Өөрийн масс	тн	7.4
3	Түлшний савны багтаамж	м ³	5
4	Дээд хурд	км/цаг	95
5	Хөдөлгүүрийн заасан чадал	кВт	70
6	Овор хэмжээ		
7	Урт	м	6.05
8	Өргөн	м	1.9
9	Өндөр	м	2.3
10	Дугуйн томъёо	-	4x2
11	Дугуйн хэмжээ	-	7.00-R16
12	Түлшний төрөл		Дизель
13	Түлшний савны багтаамж	л	80
14	Дугуйн тоо	ш	6



Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн ээлжийн түлшний хэрэглээг хүснэгт 19-д харуулав.

Хүснэгт 19. Тоног төхөөрөмжүүдийн түлш зарцуулалт

Техникийн төрөл	Тоног төхөөрөмжийн тоо	Түлш зарцуулалт, л/мото.цаг	Ээлжин дэх цэвэр ажлын цаг	Ээлжин дэх түлш зарцуулалт, л/ээлж
Экскаватор	3			1650
Hyundai R520LC	1	60	10	600
Liugong 970E	1	45	10	450
Hyundai R520LC	1	60	10	600
Автосамосвал	13			585
Tonly TL875B	9	4.5	10	405
Tonly TL875B	4	4.5	10	180
Бульдозер	1			600
CAT D9	1	60	10	600
Дугуйт ачигч	1			250
ZL-50	1	25	10	250
Ээлжинд зарцуулах түлш				3085
Түлшний машины багтаамж				6000

Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд:

Хүснэгт 20. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Техникийн нэр	То.тө марк	Хүчин чадал	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад өгсөн он	Тоо ширхэг
1	Бэлэн байгаа тоног төхөөрөмжүүд					13
1.1	Экскаватор	Hyundai R520LC	3.2 м3	2013	2015	1
1.2	Экскаватор	Liugong 970E	4.2 м3	2016	2018	1
1.3	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2021	1
1.4	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2021	1
1.5	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2021	1
1.6	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2021	1
1.7	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2021	1
1.8	Автосамосвал	Tonly TL875B	30 м3	2019	2022	1
1.9	Дугуйт ачигч	ZL-50	3 м3	2024	2024	1
1.10	Бульдозер	CAT D9	11 м3	2012	2012	1
1.11	Скруббер	СБ-100	100 м3	2021	2021	1
1.12	Дизель генератор	Komatsu-150	380 kW	2014	2014	1
1.13	Дизель генератор	Komatsu-400	380 kW	2014	2014	1
2	Нэмж авах тоног төхөөрөмжүүд					1
2.1	Автосамосвал	Tonly TL875B	40 м3	2020	2021	1

1.4.Баяжуулах технологи

1.4.1. Угаан баяжуулах элсний тооцоо ба хүчин чадал

Элс угаан баяжуулах үйлдвэр нь жилд хамгийн ихдээ 120 мян.м³ элс угаан баяжуулах бөгөөд улирлын чанартай явагдана. Угаан баяжуулах элсний хэмжээг хүснэгт № 5.7, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадлыг хүснэгт 21-д тус тус харуулав.

Хүснэгт 21. Баяжуулах элсний хэмжээ

БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Хэмжих нэгж	Бүтээгдэхүүний хэмжээ		Ашигт малтмалын нэр	Агуулга			Металл (эрдэс) хэмжээ		
	ТЭЗҮ-ийн тоон утга	Төлөвлөгөөний тоон утга		Хэмжих нэгж	ТЭЗҮ-ийн тоон утга	Төлөвлөгөөний тоон утга	Хэмжих нэгж	ТЭЗҮ-ийн тоон утга	Төлөвлөгөөний тоон утга
3	4	5	6	7	8	9	10	11	12
мян.м3			+		---			---	
мян.м3			+		---			---	
мян.м3		126.22	+	Алт (Au)	г/м3	0.19996	кг		25.24
мян.м3			+		---			---	
мян.м3	0.00	126.22	+	Алт (Au)	г/м3	0.19996	кг		25.24
мян.м3		0.95	+	Алт (Au)	г/м3	24.469	кг		23.246
мян.м3		125.27	+	Алт (Au)	г/м3	0.0159	кг		1.994

Угаан баяжуулах хэсэг нь 5 сарын 20-ны өдрөөс 9 сарын 20 хүртэл 2 ээлжээр нийт 105 хоног ажиллахаар төлөвлөлөө.

Хүснэгт 22. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

№	Үзүүлэлт	2026 он
1	Төслийн жилийн хуанлийн нийт өдөр	105
2	Жилд ажиллах сар	3.5
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа	10
4	Ээлжийн тоо	2
5	Бэлтгэл ажил хийх хоног	10
6	Засвар үйлчилгээ, цаг агаарын саатлын хоног	10
7	Баяр ёслолоор амрах хоног	10
6	Жилд ажиллах бодит хоног	75
7	Жилд ажиллах цаг	1500
8	Цаг ашиглалтын коэффициент, %	0.8
9	Жилд ажиллах бодит цаг	1200
10	Цагийн хүчин чадал, м³/цаг	100
11	Хоногийн хүчин чадал, м ³ /хоног	1143
12	Сарын хүчин чадал, м ³ /сар	34285
13	Жилд баяжуулах элсний хэмжээ, мян.м ³	120.0

1.4.2. Элс угаан баяжуулах технологи

Шороон ордыг баяжуулах үндсэн технологи нь уг ордын эрдсийн бүрэлдэхүүний онцлог, угаагдах шинж чанарт тохирсон технологийн горимыг сонгож авдаг. Тухайн ордын онцлогт тохирсон технологи нь алт агуулагч чулуулгийн найрлага, бүтэц, угаагдах шинж чанар, материалын ширхэглэлийн хэмжээ, тоосонцор алтны эзлэх хувь, агуулага, хэлбэр хэмжээ, шигшүүрийн нүхний диаметр, металл хуримтлал, технологийн ус, хатуу шингэний харьцаа, насосны даралт, усны эрчим зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаардаг.


Элс угаан задлалт: Цагаан чулуут худагийн шороон ордын алт агуулагч элс нь угаагдах шинж чанарын хувьд дунд угаагдах ангилалд багтаж байгаа учир угаан задлах ажиллагааг скруббер ашиглан гүйцэтгэнэ. Ингэснээр алт агуулагч элсийг сайтар угаан задлаж баяжуулалтанд оруулахад бэлэн болгоно. Скруббер нь +20 мм-ийн ангиллыг галийн овоолгод хураана. Харин -20 мм-ийн ангилалын элсийг шлюзэнд тэжээнэ.

Элс угаан баяжуулалт: -20 мм-ийн ширхэглэлтэй элсийг нам дүүргэлтийн шлюзээр баяжуулна. Энд том ширхэгтэй алт суух бөгөөд нам дүүргэлтийн шлюзийн баяжмал нь харьцангуй их хэмжээний элстэй байх учир алт агуулсан баяжмалыг зориулалтын саванд хийж гүйцээн баяжуулах хэсэгт авчирч баяжуулна. Хаягдал нь хаягдлын санд урсан орж тунана. Гүйцээн баяжуулахад ирсэн баяжмалыг 2 мм-ийн тортой шигшүүрээр шигшиж -2 мм ангилалын бүтээгдэхүүнийг сэгсрэх ширээгээр баяжуулах ба + 2 мм ангилалын бүтээгдэхүүн болон баяжмалыг гар тэвшээр баяжуулан соронзон ялгагчаар ялгаж хатаагаад гар аргаар үлээнэ.

Хаягдлын сан: Скрубберээс гарсан +20мм-ийн ангиллыг галийн овоолгод хураах бөгөөд нам дүүргэлтийн шлюзын хаягдлыг хаягдлын санд хураана. Сэгсрэх ширээний болон шигшүүрийн хаягдал өөрийн урсгалаар хаягдлын санд хуримтлагдах бөгөөд хаягдлын санд тунаж цэвэршсэн ус эргэлтийн усан санд өөрийн урсгалаар урсан орно. Эргэлтийн усан санд хуримтлагдсан усыг технологийн процесст эргүүлэн ашиглана.

Элс угаан баяжуулах үйлдвэрийн технологийн тооцоог дараах байдлаар тооцсон. Үүнд:


- Технологийн тоо-чанарын тооцоо;
- Технологийн ус-шлагын тооцоо;
- Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо;
- Хаягдлын сангийн тооцоо;
- Тоног төхөөрөмжийн сонголтын тооцоо;



Зураг 5. Угаан баяжуулах технологийн схем

Хүснэгт 23. Элс угаан баяжуулах технологийн тоо-чанарын нэгдсэн тооцоо

Орсон						Гарсан					
№	Бүтээгдэхүүний нэр	Q, м ³ /цаг	Au, г/м ³	γ, %	ε, %	№	Бүтээгдэхүүний нэр	Q, м ³ /цаг	Au, г/м ³	γ, %	ε, %
Угаан ангилалт											
1	Анхдагч элс	100	0.22	100	100	2	-20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	72.59	0.30	72.59	98.90
						3	+20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	27.41	0.01	27.41	1.10
	Нийт	100	0.22	100	100		Нийт	100.00	0.22	100.00	100.00
Шлюзээр баяжуулалт											
2	-20 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	72.59	0.30	72.59	98.90	4	Шлюзийн баяжмал	1.50	13.57	1.50	92.10
11	Сэгсрэх ширээний хаягдал	1.22	0.00	1.22	0	5	Шлюзийн хаягдал эфель	72.31	0.02	72.31	6.80
	Нийт	73.81	0.30	73.81	98.90		Нийт	73.81	0.30	73.81	98.90
Шигшилт											
4	Шлюзийн баяжмал	1.50	13.57	1.50	92.10	6	+2 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	0.25	0.00	0.25	0.00
						7	-2 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	1.25	16.29	1.25	92.10
	Нийт	1.50	13.57	1.50	92.10		Нийт	1.50	13.57	1.50	92.10
Гар гэвш (лотки)											
6	+2 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	0.25	0.00	0.25	0.00	8	Шлихийн алт	0.00	0.00	0.00	0.00
						9	Лоткины хаягдал	0.25	0.00	0.25	0.00
	Нийт	0.25	0.00	0.25	0.00		Нийт	0.25	0.00	0.25	0.00
Сэгсрэх ширээгээр баяжуулалт											
7	-2 мм-ийн ангиллын бүтээгдэхүүн	1.25	16.29	1.25	92.10	10	Сэгсрэх ширээний баяжмал	0.03	678.62	0.03	92.10
						11	Сэгсрэх ширээний хаягдал	1.22	0.00	1.22	0.00
	Нийт	1.25	16.29	1.25	92.10		Нийт	1.25	16.29	1.25	92.10
Гар гэвш (лотки)											
10	Сэгсрэх ширээний баяжмал	0.03	678.62	0.03	92.10	12	Шлихийн алт	0.00	20358.66	0.00	92.10
						13	Лоткины хаягдал	0.03	0.00	0.03	0.00
	Нийт	0.03	678.62	0.03	92.10		Нийт	0.03	678.62	0.03	92.10



Хүснэгт 24. Баяжуулах технологийн тоо-чанарын схем

1.4.3. Технологийн ус-шлагын тооцоо

Сонгосон технологийн схемийн дагуу ус шлагын тооцоо буюу үйлдвэрийн үндсэн дамжлагууд дээрх материалын тэнцлийг хийлээ. Ус булингын схемийн тооцоог хийснээр бүтээгдэхүүн ба үйлдэл тус бүр дээрх шингэн хатуугийн жингийн харьцаа, булингын эзлэхүүн, үйлдэлд нэмж өгөх усны хэмжээ болон үйлдлээс гарах усны хэмжээ зэрэг үйлдвэрийн усны зарцуулалтыг тооцож тодорхойлдог. Үүнд:

- Баяжуулах хүдрийн чийглэг, нягтаас хамааруулан ус-шлагын схемийг тооцоог хийж гүйцэтгэсэн;
- Баяжуулах үйлдвэрийн одоо ажиллаж буй үзүүлэлтээс бүтээгдэхүүн бүрд нэмж өгөх усны норм, хатуулаг, усны хэмжээг авч тооцсон;
- Баяжуулах процесст шаардлагатай усны хэмжээ норм, хатуулгийг стандарт нормын шаардлага хангахаар тооцож өгсөн;
- Нийт технологийн усны 70 %-ийг эргэлтийн усаар хангахаар тооцсон ба үлдсэн 30 %-ийг цэвэр усны сан буюу гүний шүүрлийн уснаас авна;
- 1 м³ элс угаан баяжуулахад 4 м³ ус зарцуулагдаж байгаа нь баяжуулалтын бүтээгдэхүүн ба усны үйлдлүүдэд нэмж өгөх усны нормыг хангаж байгаа юм;
- Ус-шлагын схемийн тооцоог гүйцэтгэхдээ дараах томъёонуудыг ашиглав.

Бүтээгдэхүүний шингэрэц :

$$R_n = \frac{(100 - S_n)}{S_n}$$

Бүтээгдэхүүн дэх усны хэмжээ:

$$W_n = R_n \cdot Q_n, \text{ м}^3/\text{цаг}$$

Булингийн эзлэхүүн:

$$L_n = Q_n \cdot \left(R_n + \left(\frac{1}{\delta} \right) \right), \text{ м}^3/\text{цаг}$$

Бүтээгдэхүүний хатуулаг:

$$S_n = \frac{100}{1 + R_n}$$

Үүнд:

Q_n – Бүтээгдэхүүний хэмжээ, м³/цаг

R_n - Хатуу шингэний харьцаа, нэгж хувь

S_n - Бүтээгдэхүүн дэх хатуугийн эзлэх хэмжээ, %

W_n - Үйлдэл тус бүрд нэмж өгч буй усны хэмжээ, м³/цаг

δ - Элсний нягт

L_n - Булингийн эзлэхүүний хэмжээ, м³/цаг

Хүснэгт 25. Элс угаан баяжуулах технологийн ус-шлагын нэгдсэн тооцоо

№	Бүтээгдэхүүнүүд	Хатуулаг, %
1	Угаах элсний чийглэг	5.0
2	Скрубберын тэжээлийн хатуулаг	21.0
3	Шлюзийн баяжмалын хатуулаг	75.0
4	Баяжуулах ширээний тэжээлийн хатуулаг	30.0
5	Шигшүүрийн тэжээлэийн хатуулаг	45.0
6	Шлихийн алтны хатуулаг	95.0
7	Галийн овоолгын хатуулаг	85.0
8	Эфелийн овоолгын хатуулаг	60.0

1.4.4. Бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ

Ил уурхайгаас олборлосон алт агуулагч элсийг угааж ангилан 20 мм-ээс дооших ангилалын элсийг гидро-шлюз, гидро-шлюзийн баяжмалыг сэгсрэх ширээгээр нийт 92.10 %-ийн металл авалттайгаар баяжуулж 876 сорьцтой 70.28 кгшлихийн алт, 61.61 кг химийн цэвэр алт гаргана. Алт гаргалтын төлөвлөгөөг доорх хүснэгтэд үзүүлэв. Алт гаргалтын төлөвлөгөөг хүснэгт № 26-д үзүүлэв.

Хүснэгт 26. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо


№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2 дэх жил
1	Баяжуулах хэсгийн ажиллах хоног	хоног	75
2	Жилд ажиллах бодит цаг	цаг/жил	1500
3	Угаан баяжуулах элс	мян.м ³	126.22
4	Элсэн дэх алтны агуулга	мгр/ м ³	0.200
5	Элсэн дэх алт /химийн цэврээр/	кг	25.2
6	Металл авалт /химийн цэврээр/	кг	23.2

1.4.5. Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжүүд

“Дамбат” ХХК нь элс угаан баяжуулах хэсгийн скруббер, шлюз, сэгсрэх ширээ, хүрдэн шигшүүр насос зэрэг хуучин төхөөрөмжүүдээ ашиглана.

Технологийн туршилтын үр дүн, санал болгосон технологийн схем, захиалагч компанийн санал болгосон тоног төхөөрөмжийг үндэслэн тоног төхөөрөмжийн холболтын зургийг боловсрууллаа.

Угаан баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтын зураг 6-д үзүүлээ.



Зураг 6. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем

Зургийн тайлбар: 1-Элсний овоолго, 2-Дугуйт ачигч, 3-Бункер, 4-Угаах төхөөрөмж, 5-Галийн овоолго, 6-Гүн дүүргэлтийн шлюз, 7-Хүрдэт шигшүүр, 8-Сэгсрэх ширээ, 9-Лотки, 10-Шлихийн алт, 11-Тунаах нуур, 12-Эргэлтийн усан сан, 13-Насос, 14-Цэвэр ус;

Скруббер: Цагаан чулуут худаг алтны шороон ордын хувьд “Скруббер-100” гэдэг ихэнх шороон ордод хэрэглэдэг угаах төхөөрөмжийг ашигладаг. Уг төхөөрөмж нь бункер, угаах агрегат, шлюз, насосны станц зэргээс бүрдэнэ. Угаах төхөөрөмж нь хоногт 20 цаг ажиллах ба Х:Ш=1:4 харьцаагаар тохируулан баяжуулах үйл ажиллагаа явагдана.

Угаах төхөөрөмжийн бункерыг утгуурт ачигчиар тэжээн өгч угаасны дараа +20 мм ангилалын бүтээгдэхүүн хаягдаж галийн овоолго үүсгэнэ. Харин -20 мм ангилал шлюзэнд орж баяжигддаг. Ийнхүү угаах үйл ажиллагаа тасралтгүй 20 цаг явагдсаны дараа шлюзийн баяжмалыг (ойролцоогоор 1.5 м³) авч гүйцээн баяжуулах хэсэгт ахин баяжуулж цэвэр металлыг гарган авна

Хүснэгт 27. Угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлт


№	Үзүүлэлт	Скруббер-100
1	Бүтээл, м ³ /цаг	100
2	Скрубберын тэжээлийн ширхэглэл, мм	100-200
3	Хүрдний диаметр, м	2.1
4	Скрубберын налууугийн өнцөг, град	3-5
5	Цахилгаан зарцуулалт, кВт/цаг	55
6	Жин, кг	18000
7	Ашиглагдах тоо	1
8	Үйлдвэрлэсэн улс, он	Монгол



Сэгсрэх ширээ: Угаан баяжуулах үйлдвэр нь нэг ширхэг баяжуулах ширээтэй байх ба шлюзийн баяжмалыг баяжуулж шлихийн алт гарган авах үүрэгтэй байна. Ус-шлагмын тооцоогоор баяжуулах ширээнд орох баяжмал нь 1.25 м³ байна.

Хүснэгт 28. Сэгсрэх ширээний техникийн үзүүлэлт


№	Үзүүлэлт	СКО-2
1	Бүтээл, тн/цаг	1.2
2	Тэжээлийн ширхэглэл, мм	0.2-2.0
3	Тавцангийн хэлбэр	трапец
4	Тавцангийн талбай, м ²	2
5	Тавцангийн хөдлөх давтамж, мин ⁻¹	0.6-16.0
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	1.5
7	Эргэх давтамжийн тоо, мин ⁻¹	920
8	LxВxН, мм	2200x1000x180
9	Жин, кг	207
10	Ашиглагдах тоо, ширхэг	1



Усан хангамжийн тоног төхөөрөмж: Баяжуулах хэсгийн усан хангамжийн хэсэгт технологийн ус болон шаардлагатай цэвэр усыг шахах насосыг ажиллуулна.

Хүснэгт 29. Технологийн ус шахах насосны техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	1Д500-636
1	Хүчин чадал, м ³ /цаг	400
2	Өргөх өндөр, м	44
3	Эргэлтийн хурд, эрг/мин	1450
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	110
5	Суурьлагдах тоо, ширхэг	1
6	Ашиглагдах тоо, ширхэг	1



Хүснэгт 30. Угаан баяжуулах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлтүүд							
		Марк	Хүчин чадал	Хөдөлгүүрийн чадал	Ажиллах тоо /ш/	Нийт хөдөлгүүрийн чадал	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд өгсөн хугацаа	Ашиглалтын жил
1	Скруббер	100	Q=100 м ³ /цаг	55.0	1	55.0	2021	2021	4
2	Хүрдэн шигшүүр	YTS-600	Q=1-10 т/цаг	1.5	1	1.5	2021	2021	4
3	Баяжуулах ширээ	СКО-2	Q=1.2 т/цаг	1.5	1	1.5	2021	2021	4
4	Технологийн усны насос	1Д 500-636	400 м ³ /цаг	110.0	1	110.0	2021	2021	4
5	Цэвэр усны насос	ЭЦВ6-10-160	250 м ³ /цаг	25.0	2	50.0	2021	2021	4
Нийт				193.0	6	218.0	2021	2021	4

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1.Физик газарзүй

“Дамбат ХХК-ний Цагаанчулуут худаг нэртэй алтны шороон орд нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн хойш 730 орчим км, Чойбалсан сумаас баруун хойш 211 км, Баяндун сумаас хойш 35 км, Түргэн багийн төвөөс зүүн хойш 7 орчим км-т тус тус зайтай оршино. Баяндун сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Монгол дорнод хэсгийн давхаргат болон суурьт өндөрлөг тал, тэгшдүү хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уулын муж болон Онон-Улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээр гэсэн 2 хэв шинжийн физик газарзүйн мужлал тус сумын нийт газар нутгийг эзэлнэ. Онон-Улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээр нь Баяндун сумын нийт газар нутгийн 95 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд төслийн талбайн байршил орчмын болон төслийн талбай нь тус мужлалд багтаж байна. Харин тухайн төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршил нь нам уулсын систем бүхий, хээрийн бүс нутгийн хэв шинжтэй газар болох нь 2026 оны 03 сарын 28-31 хооронд төслийн талбайн байршилд хийсэн байгаль орчны төлөв байдлын шатанд тодорхой болсон.

2.2.Цаг уур, уур амьсгал

Дорнод аймгийн уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Агаарын температурын хамгийн их ба бага утга 6-р сард, 1-р сард илэрнэ. 6-р сарын агаарын хамгийн их температурын утга нь 36.4°C, 1-р сарын агаарын температурын хамгийн бага утга нь -31°C байна.

Төслийн хэрэгжих талбай орчмын нутаг нь хур чийг бага, хуурайшил ихтэй бүсэд багтаж жилийн нийлбэр хур тунадас нь 302.5мм, дулааны улиралд 282.5мм, хүйтний улиралд 20мм байна. Хур тунадас нь зун, намрын улиралд зонхилон тохиолдох бөгөөд энэ нь нийт хур тунадасны 80-95%-ийг эзэлнэ. Хур тунадасны жилийн нийлбэрийн олон жилийн өөрчлөлтийг авч үзэхэд хур тунадасны жилийн нийлбэр төсөл хэрэгжих бүс орчмоор сүүлийн жилүүдэд маш бага хэмжээгээр буурсан хандлагатай байна.

Дорнод аймгийн хувьд салхи хойд, баруун хойноос ноёлох чиглэлтэй. Салхины чиглэлийн давтагдал жилийн аль ч сард голын хөндий уултай нутагт салхины баруун хойд чиглэл 30-40% давтагдалтай байхад зүүн чиглэлийнх нь бараг давтагдалгүй байна. Салхины үнэмлэхүй их хурдны хамгийн бага утга нь 2,8-р сард бөгөөд салхины хурд 13м/с-14м/с байна.

Төсөл хэрэгжих бүс орчмоор салхины үнэмлэхүй их хурдны жилийн дундаж их хурд 17.25м/с байна. Салхины хурдны их утга нь хавар намрын улиралд ажиглагдах бөгөөд 3-6 дугаар сард 16м/с-21м/с хүрдэг байна. Өвлийн улиралд салхины хурдны бага утга нь ажиглагдана.

Төслийн хэрэгжих талбай орчмын нутаг нь хур чийг бага, хуурайшил ихтэй бүсэд багтаж жилийн нийлбэр хур тунадас нь 302.5мм, дулааны улиралд 282.5мм, хүйтний улиралд 20мм байна. Хур тунадас нь зун, намрын улиралд зонхилон тохиолдох бөгөөд энэ нь нийт хур тунадасны 80-95%-ийг эзэлнэ. Хур тунадасны жилийн нийлбэрийн олон жилийн өөрчлөлтийг авч үзэхэд хур тунадасны жилийн нийлбэр төсөл хэрэгжих бүс орчмоор сүүлийн жилүүдэд маш бага хэмжээгээр буурсан хандлагатай байна.

Нарны гийгүүлэл жилдээ 2733 цаг үргэлжилдэг нь боломжит хугацааны 60% орчмыг эзэлдэг орчны уул зүй, өглөө оройн нарны халхлагдах болон хот орчмын үүлшил, агаарын булингаршил, хотын цаг агаартай холбоотой буурдаг. Нарны гийгүүлэл хоног, сар, жилийн хугацаагаар цэлмэг үед нэн тодорхой явцтай байна. Нэг өдөрт дунджаар жилдээ 7-8 цаг нар гийгүүлэхдээ үүлшлээс хамаарч хэлбэлзэх боловч зуны саруудад 8.5-9.6 цаг, өвлийн саруудад богиносож 5-6.5 цаг нартай байдаг.

Нарны цацраг, гийгүүлэл, үүлшил, нарны өндрөөс ихээхэн хамааран жилдээ нийлбэр цацраг 4390 мДж/м², шулуун цацраг 2676 мДж/м² тус тус ирдэг. Нарны цацраг нарны өндөр ихэссэн, үүлшил бага байдаг 5,6 дугаар саруудад хамгийн их, нарны өндөр хамгийн бага 12 сар болон өвлийн саруудад бага байдаг.

2.3.Төслийн талбайн байршилд хийсэн агаарын хэмжилт судалгаа

Төслийн талбайд 2026 оны 03-р сарын 31-ны өдөр Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн орчны хяналт, шинжилгээний албаныханд тавьсан хүсэлтийн дагуу тухайн өдөр төслийн байршилд агаарт агуулагдах хорт хий болон агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох зорилгоор нэг удаагийн хэмжилтийг явуулсан. Тухайн хэмжилтийн үр дүнг дараах хүснэгтээс харж болохоор байна.

Энэхүү ажилд нийт 2 судлаачийн бүрэлдэхүүн оролцож ажилласан. (Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Ж.Гэрэлтуяа, “Санлотус” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн М.Цэрэн-Очир) гэсэн судлаачдын бүрэлдэхүүн тухайн талбайн агаарын чанарын шинжилгээ, судалгааг явуулсан байна.

Хүснэгт 31. Төслийн талбайн агаарын чанарын төлөв байдал (Ажиллаж байх хугацааных), (20 мин сорьц)

№	Агаарын сорьц авсан цэгийн нэр	Сорьц авсан цаг	Агаарын даралт	Агаарын температур	Азотын давхар исэл	Хүхэрлэг хий	Нийт тоосонцор
			гПа	°С	мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³
1	Эрүүл хөрс, хойд зүгт	13:39	921.8	6.4	20	5	445
2	Шимт хөрсний овоолго	14:13	921.5	6.8	18	4	64
3	Кемпийн гадаа	14:54	921.1	7.2	18	4	46
4	Ажилчдын байр	15:20	920.8	6.8	16	3	46
5	Ашиглалт явуулах талбай	16:02	920.8	5.5	20	5	49
Хүлцэх агууламж: MNS 4585:2016					200	450	500

Дээрх хүснэгтээс авч үзэхэд төслийн талбайн байршилаас авсан агаарт хүлцэх хэмжээнээс давсан бохирдол илрээгүй ба тухайн талбайн агаарын чанар одоогийн байдлаар эрүүл байна.

2.4.Төслийн талбайн дуу чимээний хэмжилт судалгаа

Төслийн үйл ажиллагаа явуулах, явуулж байгаа талбайн байршилд 3-р сарын 31-нн а өдөр агаарын чанарын судалгаа явуулахад давхар тухайн орчны дуу чимээний түвшин нь дараах байдлаар илэрсэн тогтоогдсон.

Хүснэгт 32. Дуу чимээний хэмжилтийн үр дүн

№	Хэмжилт хийсэн газар	Дууны түвшний доод утга, дб	Дууны түвшний дунд утга, дб	Дууны түвшний дээд утга, дб
1	Төслийн талбайд	48.9	52.0	75.8

Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршил орчмоос авсан дуу чимээний бохирдлын түвшин нь ДЭМБ-аас хүлцэх хэмжээ нь 60 дб хэмээн тогтоосон хүлцэх агууламжаас бага үзүүлэлттэй байсан. Харин үйлдвэрийн тоног төхөөрөмж ажиллаж байх болон том оврын автомиксер машин бүтээгдэхүүн авч байх явцад хамгийн өндөр утга болон 75.8 дб-д хүрч хүлцэх хэмжээнээс даруй 15.8 дб-ийг давж байгаа нь төслийн үйл ажиллагаанд ажиллаж буй ажилчид эрүүл бус нөхцөлд ажиллаж байгаа нь харагдаж байна.

2.5.Төслийн талбайн геологийн судалгаа¹

Түргэний алтны зангилааны хэмжээнд протерозойгоос дөрөвдөгч хүртэлх насны өөр хоорондоо тектоник хөдөлгөөн болон метоморфизмд өртсөн байдлаараа эрс ялгаатай олон янзын найрлага, бүрэлдэхүүнтэй хурдсууд тархсан байдаг байна. Үүнд дээд протерозойн, девоны пермийн, юрийн, цэрдийн, неогенийн ба дөрөвдөгчийн галавын хурдсууд хамаарах аж.

Дээд протерозой (PR₂): 1968 онд Эрээн давааны нуруунд В.А. Благонравов нар дээд протерозойн хурдсыг Хайчийн гол, Эрээн давааны свитүүдэд ялгасан байна. Тус талбайд Хайчийн голын свитын хурдас тархдаг бөгөөд өргөргийн дагуу чиглэлтэй шугамын атираажилтанд орсон байдаг байна.

Хайчийн голын формац (PR₃^{hc}): нь гантигжсан саарал өнгийн доломит, хар саарал өнгийн паралель текстуртай амфиболит, шохойн чулуу, бараавтар ногоон, цул, эрчимтэй, амфиболитжсон мета-андезит, амфибол-хээрийн жонш-кварц, эпидот-хлорит, кварц-мусковитод, цайвар ногоон скарнжсан эпидот-кварц-гранаттай, кварц-биотит-серцититтэй, кварц-мусковит-хлориттой занарууд, биотиттой плагиогнейс, пироксен-амфибол-кварц-плагиоклазтай гнейс, амфибол-хээрийн жоншит гнейсүүдээс тогтох аж. Талбайд тархсан Хайчийн голын формацын нийт зузаан ойролцоогоор 800 м аж.

Дунд-дээд юра (J₂₋₃): 1988-1991 онуудад Л.Ганбаатар нар Улз голын зүүн эрэг, Түргэний голын сав газарт тархсан дунд-дээд юрын вулконоген-тунамал хурдсыг бүдүүн хэмхдэст холимог, хүчиллэг-дундлаг найрлагатай эффузивийн гэсэн 2 зузаалагт ангилсан байна. Эхний доод зузаалагт: конгломерат, туфоконгломерат бүхий гравелит туфогравелитийн үеийг дээд хэсэгтээ агуулсан элсэн чулуу, доод зузаалагт далд ба урсгал текстуртэй риолит, андезит, шигтгээт базальт, трахиандезитыг тус тус хамааруулжээ.

¹ “Дамбат” ХХК-ийн MV-000400 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн алтны шороон ордыг ил аргаар олборлох төсөл

Доод цэрдийн Цагаан цавын формац (K1CC): эх газрын бүдүүн хэмхдэст терриген хурдас аж. Мөн суурилаг-дундлаг найрлагатай эффузивээс тогтох цагаан цавын свитийг хамааруулдаг байна. Л.Ганбаатар нар өөрсдийн судалгааны материалд тулгуурлан цагаан цавын свитийн хурдсыг доод цэрдийн настай гэж үзжээ. Уг свитийн хурдас хучдас хэлбэрийн биетийг үүсгэн нэлээд бага талбайд тархалттай, цул, нүх сүвэрхэг миндалин текстуртэй базальт, андезит-базальт, шигтгээт андезит-базальт, шигтгээт-базальт, аливинт базальт, туфобрекчи зэргээс бүрдэх аж.


Неогений ангилагдаагүй хурдас (N): Неогений хурдас Улзын грабень-синклиналын хойт хэсгээр Цагаанчулуут худгийн доод бие, Гүн-өндөрийн хөндий түүний харалдаа, Түргэний голын баруун эргээр тархсан аж. Неогений хурдаст хайрга, хайрганцарын хэмхдэс бүхий улаан, улаан хүрэн өнгийн занар нарийн, жижиг мөн бүдүүн ширхэгт полимикт найрлагатай элс зэргийг хамааруулсан байна.

Дээд плейстоцен-голоцений хурдас (QI): Дөрөвдөгчийн хурдас дотор хамгийн түгээмэл тархсан бөгөөд делювиаль-пролювиаль гаралтай хурдсаас тогтох аж. Ихэнхдээ хотгорын захын хэсэгт уулсын хажуу бэлээр голлон тохиолддог байна. Хурдас нь ихэвчлэн том хэмхдэст сул барьцалдсан тод илэрсэн хэмнэл бүхий бүтэцтэй байна. Хэмхдэсүүд нь өнцөглөсөн хэлбэртэй байдаг байна. Цемент нь голдуу элс, элсэнцэр, шавранцар, жижиг үйрдэст материал байдаг. Хамгийн том хэмхдэст материалууд хурдсын дээд хэсэгт зонхилон тохиолдох аж. Мөн хэмхдэсийн эзлэх хувь уулсын бэл хормойд ойртох тусам ихэсдэг байна. Делювиаль-пролювиаль хурдсын петрографын найрлага тэдгээрийн ул болж буй суурь чулуулгийн найрлагаас шууд хамаардаг байна. Ихэвчлэн боржингийн, занарын, элсэн чулууны, хүчиллэг ба суурилаг эффузивийн хэмхдэсүүд тохиолддог аж. Хурдас хуримтлал нь гравитацийн шилжилт, мөн цасны болон борооны усны нөлөөгөөр явагдаж буй талбайн угаагдлын үр дүнд уулын хажуугаас намхан рельефтэй хэсэгт хэмхдэст материал зөөгдөн ирж хуримтлагдаж байгаатай холбоотой аж. Хурдсын зузаан 3-15 м хүрдэг байна.

Голоцен хурдас (QII) (Дээд дөрөвдөгчийн): хурдас ихэвчлэн тусгай зөвшөөрлийн талбайн үндсэн морфоструктуруудад хөндлөн чиглэлтэй Цагаанчулуут худаг, Цагаанчулуут хоолой, Гүн-Өндөрийн булаг, Өвөлжөөт, Рашаант, Баянгол зэрэг томоохон хөндийнүүдэд тогтоогдсон ба тэдгээрийн эртний голдирол дахь аллювийн хурдсаас бүрддэг байна. Дээд дөрөвдөгчийн хурдас нь залуу насны сэвсгэр хурдсанд бүрэн хучигдах бөгөөд орчин үеийн гадаргууд илрээгүй зөвхөн өрөмдлөгөөр судлагдсан аж. Хурдас нь дахин зөөгдсөн неогенийн өгөршлийн бүрхүүлийн бүтээгдэхүүн улаан өнгийн шавранцар зонхилсон хайрга, хайрганцар, элсэнцрийн үеүдээс тогтох аж. Энэ хурдаст талбай дахь алтны голлох томоохон шороон ордуудын доод давхрага агуулагддаг байна. Зузаан нь 10-30.1 м хүрдэг байна. Аллювийн хурдсууд түр зуурын болон тогтмол урсгалтай ус бүхий хөндийнүүд, голдирол том жижиг гуу жалгуудаар хөгжсөн аж. Эдгээр нь хагас мөлгөржсөн хайрга, сайрга бүхий элс, элсэнцэр, шавранцраас голлон тогтдог байна. Зузаан нь харьцангуй бага хамгийн ихдээ 11 м хүрдэг байна.

2.6. Гадаргын усны судалгаа

Төслийн талбайн орчим гадаргын усны сүлжээ багатай ихэнх улирлын чанартай ширгэж замхарна. Талбайн хэмжээнд усан сүлжээ ойролцоо урсах томоохон гол нь Түргэний гол болон Улз гол юм.



Зураг 7. Төслийн талбайн байршилтай хамгийн ойр байрлах голын сүлжээ

Төслийн талбайн байршилд хийсэн судалгаагаар тухайн төслийн талбайн байршил нь гадаргын уст цэгтэй давхцалгүй буюу хамгаалалтын бүсээр давхцалгүй байх ба Түргэний голоос 9.5 км зайтай, Улз голоос 7.6 км зайд оршиж байна.

2.7. Газрын доорхи усны судалгаа

Цагаан чулуут худгийн алтны шороон орд нь Улзын усан хагалбарын системийн Улз голын зүүн эрэгт уртрагийн дагуу салбарласан уулсын дунд хуримтлагдан тогтсон байна. Цагаан чулуутын хөндий нь цагариган структурын хүрээнд байрладаг бөгөөд хөндийн нийт урт нь 16 км, өргөн нь дээд хэсэгтээ 40-200 м, дунд хэсэгтээ 200-500 м, доод хэсгээрээ 1100 м хүрч өргөсдөг байна.

Дүүргийн газрын доорх ус нь палеозойн эриний тунамал хувирмал чулуулаг болон гүний чулуулгийн ан цавлаг бүс, түүнчлэн орчин үеийн хөндий, уулс хоорондын хөндийнүүдийг дүүргэсэн мезозой-кайнозойн сэвсгэр хурдсанд тохиолддог байна. Гадаргуугийн урсгалтай Улз, Түргэний голууд тус бүсд байдаг байна. Улз голын урт нь ойролцоогоор 328 км бөгөөд дундаж унал нь бүх уртад 1 км тутамд 1.2 км аж. Улз голын өргөн 3-7 м, усны урсгалын хурд 0.7-1.0 м/сек, дундаж гүн нь 1.2 м хүрдэг байна. Тус дүүргийн хамгийн том гол нь Улз аж. Хөндийн өргөн нь 1-2 км хүрдэг байна.

Хүснэгт 33. Цагаанчулуут худаг талбай дахь тогтоол устай нуурын шинжилгээний хариу


№	Элемент	Нэгж	Шинжилгээний дүн	Зөвшөөрөгдөх хэмжээ	Стандартын арга
1	pH	-	8.04	6.5-8.5	MNS ISO
2	Кали (K ⁺)	мг/л	2.03	-	MNS 5465:2005
3	Натри (Na [*])	мг/л	17.42	200.0	
4	Кальци (Ca ^{2*})	мг/л	64.89	100.0	MNS ISO 2572-1999
5	Магни (Mg ²⁺)	мг/л	25.15	30.00	
6	Аммони, (NH [*])	мг/л	<0.10	1.50	MNS ISO 7150-
7	Хлорид, (Cl)	мг/л	5.10	350.0	MNS ISO 9297:2005 MNS 3652.4:1984
8	Сүльфат (SO ₄ ²⁻)	мг/л	84.89	500.0	MNSISO
9	Нитрит (NO ₂)	мг/л	<0.05	1.00	MNS 4431:2005
1	Нитраг, (NO ₃ [“])	мг/л	1.98	50.00	MNS ISO 7890-
1	Карбонат (CO ₃ ^{2~})	мг/л	7.50	-	MNS ISO 9963-1:2005
1	Гидрокарбонат (HCO ₃ ²)	мг/л	231.9	-	
1	Нийт хатуулаг	мг-	5.31	7.00	
1	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	346.0	1000	MNS 4423:1997
1	Цахиурын хүчил, H ₂ SiO ₃	мг/л	15.16	-	MNS 4343-1996
1	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₇ /л	0.96	-	MNS ISO 4889:1999
1	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1	
1	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.50	
1	Мышьяк, As	мг/л	0.01	0.01	
2	Бор, B	мг/л	0.01	2.40	
2	Бари, Ba	мг/л	0.03	0.70	
2	Берелли, Be	мг/л	<0.001	0.0002	
2	Кадми, Cd	мг/л	<0.001	0.003	
2	Кобальт, Co	мг/л	<0.001	•	
2	Хром, Cr	мг/л	<0.005	0.05	
2	Зэс, Cu	мг/л	<0.02	2.0	MNS (ISO) 11885:2011
2	Төмөр, Fe	мг/л	0.04	0.3	
2	Марганец, Mn	мг/л	<0.01	0.1	
2	Молибден, Mo	мг/л	0.03	0.07	
3	Никель, Ni	мг/л	<0.005	0.02	
3	Хартугалга, Pb	мг/л	<0.01	0.01	
3	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.02	
3	Селен, Se	мг/л	0.015	0.04	
3	Стронци, Sr	мг/л	0.43	2.00	
3	Уран, U	мг/л	<0.03	0.03	
3	Цайр, Zn	мг/л	<0.01	5.0	

Тайлбар: Төслийн үйл ажиллагаа явуулах талбайн байршил орчмоос дээж авахад хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт бүхий бохирдол илрээгүй болно.

2.8. Хөрсний судалгаа

Дорнод аймгийн Баяндун сумын нутаг Цагаан чулуут нэртэй талбайд орших MV-000400 тусгай зөвшөөрөлтэй талбайн төслийн судалгаагаар төслийн талбайд хөрсний үндсэн зүсэлт, бичиглэлийг гүйцэтгэсэн бөгөөд дээжлэлт “Green lab” ХХК хөрс судлалын лабораторт хийсэн. Судалгааны ажилаар нийт 2 хэв шинжийн хөрс ялгасаныг зургаар


үзүүлэв. Үүнд: Элсэрхэг цайвар хүрэн хөрс, Сайргархаг цайвар хар шороон хөрс, Сайрын элсэн болон хайргархаг хөрснүүд юм.



Зураг 8. Төслийн үйл ажиллагаа явуулах талбайн байршил хөрсний бүлгээр

Карбонатгүй хар шороон хөрс нь хээрийн бүсэд түгээмэл тархсан байдаг ба тухайн хөрсний үржил шимийн зузаан нь төдийлөн их биш. Сайргархаг нимгэн хар шороон хөрс нь Баяндун сумын нутагт түгээмэл тархсан байх ба тус хөрс нь ихэвчлэн бага налуу, хэрчигдэлтэй хээрийн бүс болон бага уулсын систем бүхий талбайд түгээмэл тархана. Харин төслийн талбайд хийсэн судалгаа шатанд тухайн талбайн хөрсний хэв шинж нь цайвар хүрэн өнгийн бага зэргийн шаварлагтай элсэрхэг голдуу хөрс байв.

Хүснэгт 34. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-1

Хөрсний зүсэлт: Шимт хөрсний овоолго	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, шимт хөрсний овоолго
	Координат: ХӨ 47 ⁰ 471519 ЗУ 113 ⁰ 417483
	Газрын гадарга: Толгодын бэл хормой
	Бичил гадарга: Техникийн үйл ажиллагаагаар шимт хөрсийг хуулан овоолсон талбай
	Налуу: 0-50° (градус)
	Гадаргын чулуу: 5-40 мм хэмжээтэй чулуу тархсан
Чулууны бүрхэц %:	0-5 %
Хөрсний эвдрэл:	Өөр орчинд тээвэрлэж овоолго байдлаар хадгалсан байна.
Эвдрэлийн хэлбэр:	Техноген
Зонхилох ургамал:	Хээрийн хялганат-алаг өвст, гичгэнэ, азаргана, цахилдаг, бусад үетэн ургамлууд
Ургамал бүрхэц	80 орчим хувь нь ургамлан бүрхэвчээр хучигдсан. Харин хайрган хучаас бүхий газарт ургамалгүй
Хөрсний нэр: Шаварлаг цайвар хүрэн өнгийн хөрсний хэв	
Шимт хөрсний овоолго: Хүрэн өнгөтэй, элсэрхэг бүтэцтэй цөөн тооны чулуулаг тархсан. Карбонатын тархалтгүй, бөөмөрхөг бүтэцтэй. 2-5 мм хэмжээтэй хэмхдэс чулуулаг 10-15% тархсан.	

Хүснэгт 35. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/

№	Лаб №	Дээжний байршил	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ	СО ₂ , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриуд, экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Са+Mg	Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	25/2623	47 ⁰ 471519 113 ⁰ 417483	0-5	9.23	0.03	0.061	0.49	1.28	20.3	15.5	4.8	1.2	38

Тайлбар:

Төслийн үйл ажиллагаа явуулаар төлөвлөж буй талбайн байршил орчимд байх өмнө нь хуулагдсан шимт хөрсний овоолгоос дээж авч шинжилгээнд хамруулахад төдийлөн өөрчлөлт гараагүй болно. Энэ нь ялзмаг шим тэжээлийн агуулга бага түвшний шимт хөрс байсан ба тухайн шимт хөрс нь үл ялиг давсжилттай цахилгаан дамжуулах чадвар сулавтар, карбонатын агууламж өндөр гарсан байна.


Хүснэгт 36. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	25/2623	47°26'12.05" 113°26'05.01"	0-5	45.3	18.5	12.6	4.5	12.2	6.9	23.6

Тайлбар:

Шимт хөрсний овоолгод хадгалагдаж буй шимт хөрс нь тоосорхог агууламж багавтар сул шаварлагтай элсэнцэр ангиллын хөрс байна.

Хүснэгт 37. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-2

Хөрсний зүсэлт: Хөрсний овоолго	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, хөрсний овоолго орчмын нөхөн сэргээлт хийсэн талбай
	Координат: ХӨ 49°27'31.40" ЗУ 113°25'15.74"
	Газрын гадарга: Тэгшивтэр уулын дэнж
	Бичил гадарга: Замын баруун хэсэг
	Налуу: 5-15° (градус)
	Гадаргын чулуу: 5-10 мм хэмжээтэй чулуу тархсан
	Чулууны бүрхэц %:
Хөрсний эвдрэл:	Техногений нөлөөллөөр зарим хэсгийн талбайн нөхөн сэргээлтийн талбай нь эвдрэлд орсон
Эвдрэлийн хэлбэр:	Техноген
Зонхилох ургамал:	Хээрийн хялгана, дааган сүүл
Ургамал бүрхэц:	Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил орчимдоо ургамлын тархалт сийрэг, цөөн төрөл, зүйлийн ургамал ургасан
Хөрсний нэр: Хээрийн цайвар шороон хөрсний хэв	
А үе (0-10 см): Цайвар шаргал өнгийн шороон хөрс- сулавтар шаварлагтай, ихэнх бүрэлдэхүүн нь хар шороон хөрс эзлэх шинжтэй, дараагийн үед шилжихдээ өнгөөр	

үл ялимаг ялгарна. Үндэсний тархалт энэ үед гүехэн байх ба 10 см хүртэлх гүнд үргэлжилж байна.

Хүснэгт 38. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/

№	Лаб №	Дээжний байршил	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ	СО ₂ , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриуд, экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Са+Mg	Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	25/2625	49°27'31.40" 113°25'15.74"	0-10	8.75	0.03	0.062	0.00	0.83	23.2	19.4	3.8	1.3	29

Тайлбар:

Төслийн үйл ажиллагаа явуулаар төлөвлөж буй талбайн байршил орчимд байх өмнө нь нөхөн сэргээлт хийж байсан талбайгаас дээж авч шинжилгээнд хамруулсан болно. Энэ нь ялзмаг шим тэжээлийн агуулга бага түвшний шимт хөрс буюу үржил шимт үеийн зузаан бага байсан ба тухайн хөрс үл ялиг давсжилттай цахилгаан дамжуулах чадвар сулавтар, карбонатын агууламж өндөр гарсан байна.

Хүснэгт 39. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	25/2625	49°27'31.40" 113°25'15.74"	0-10	34.0	24.9	14.3	8.4	11.4	6.8	26.6

Тайлбар:

Хөрсний овоолго орчимд хадгалж буй талбай нь тоос болон шаврын агууламж багавтар элс хайрганы агууламж өндөр хөрс байна.

Хүснэгт 40. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-3

Хөрсний зүсэлт: Засварын талбай	
	
Огноо: 2026-03-31	
Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, Засварын талбай	
Координат: ХӨ 47 ⁰ 25'53.72" ЗУ 113 ⁰ 25'53.73"	
Газрын гадарга: Тэгшивтэр тал	
Бичил гадарга: Техникийн үйл ажиллагаагаар үүссэн үүсмэл хайрган хучаас бүхий газрын хажуу	
Налуу: 0-50° (градус)	
Гадаргын чулуу:	5-40 мм хэмжээтэй чулуу тархсан
Чулууны бүрхэц %:	0-5 %
Хөрсний эвдрэл:	Өөр орчинд тээвэрлэж овоолго байдлаар хадгалсан байна.
Эвдрэлийн хэлбэр:	Техноген
Зонхилох ургамал:	Хээрийн хялганат-алаг өвст, гичгэнэ, азаргана, цахилдаг, бусад үетэн ургамлууд
Ургамал бүрхэц:	80 орчим хувь нь ургамлан бүрхэвчээр хучигдсан. Харин хайрган хучаас бүхий газарт ургамалгүй
Хөрсний нэр: хар шороон хөрсний хэв	
<p>А үе (0-7 см): цайвар хүрэн-шаргал өнгөтэй, том хэмжээтэй хэмхдэс чулуу тархаагүй байна. 0-5 см-ийн гүнд үндэсний тархалт дунд зэрэг байна. Карбонатын тархалтгүй, бөөмөрхөг бүтэцтэй. 2-5 мм хэмжээтэй хэмхдэс чулуулаг 10-15% тархсан.</p>	

Хүснэгт 41. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-1

№	Лабораторийн дугаар	Дээжний дугаар	Дээжний тодорхойлолт	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг				
				Na	Ca	Mg	K	Fe _{нийт}	As	Ba*	Be	Bi	Cd
1	Л-2159	Хөрс-3	Засварын талбай	2.28	2.57	0.74	2.42	2.95	11.59	738.2	1.88	<10.0	<1.0
2	Л-2160	Хөрс-4	Кемпийн талбай	2.12	5.56	0.95	1.83	3.92	17.55	643.5	1.28	<10.0	1.12
3	Л-2161	Хөрс-7	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	1.84	2.93	0.77	2.35	3.64	15.62	777.7	1.95	<10.0	<1.0
4	Л-2162	Хөрс-8	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	1.85	0.87	0.38	3.25	2.09	10.34	581.9	3.25	<10.0	<1.0
MNS5850:2019				-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00

Хүснэгт 42. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-2

№	Лабораторийн дугаар	Дээжний дугаар	Дээжний тодорхойлолт	ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb
1	Л-2159	Хөрс-3	Засварын талбай	15.63	55.76	28.20	18.36	20.51	558.6	<5.0	25.28	713	13.00
2	Л-2160	Хөрс-4	Кемпийн талбай	18.01	50.91	28.86	17.53	16.13	1076.81	<5.0	22.06	786	13.20
3	Л-2161	Хөрс-7	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	13.92	62.07	46.69	20.47	23.13	761.1	<5.0	21.99	593	25.09
4	Л-2162	Хөрс-8	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	7.64	31.48	17.03	19.89	35.14	511.9	<5.0	12.13	309	24.59
MNS5850:2019				50.00	150.0	100.0	-	-	-	5.00	150.0	-	100.0

Хүснэгт 43. Хөрсөнд агуулагдах хүнд металлын үзүүлэлт-3

№	Лабораторийн дугаар	Дээжний дугаар	Дээжний тодорхойлолт	ЭЛЕМЕНТ, мг/кг							
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*
1	Л-2159	Хөрс-3	Засварын талбай	<10.0	<5.0	432.7	3637	91.63	21.63	44.6	54.3
2	Л-2160	Хөрс-4	Кемпийн талбай	<10.0	<5.0	648.8	4061	143.7	23.08	45.8	28.1
3	Л-2161	Хөрс-7	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	<10.0	<5.0	364.1	3467	89.6	22.32	65.9	62.4


№	Лабораторийн дугаар	Дээжний дугаар	Дээжний тодорхойлолт	ЭЛЕМЕНТ, мг/кг							
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*
4	Л-2162	Хөрс-8	Шлам /угаагдсан элсний овоолго-1/	<10.0	<5.0	178.5	2330	41.1	19.05	53.2	112.8
MNS5850:2019				-	10=,00	800.0	-	150.0	-	300.0	-

Төслийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй талбайн байршил орчимд судалгаа явуулахад хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлттэй бохирдолтой талбай байсангүй. Харин хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлттэй хамгийн ойрхон бохирдолтой байгаа талбай кемпийн дотор авсан хөрсний дээжээс ванади V илэрсэн үзүүлэлт нь хүлцэх хэмжээтэй хамгийн ойр байсан үзүүлэлт болсон байна.

Хүснэгт 44. Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт

№	Лаб №	Дээжний тодорхойлолт	Дээжний хэмжээ /гр/	Үзүүлэлт				
				Бактерийн ерөнхий тоо	Колиформ гэдэсний бүлгийн гэдэсний нянгийн таньц	Халуунд гэдэсний нянгийн таньц	тэсвэртэй бүлгийн	Клостридиум перфрингенсийн таньц
1	Л-272	Кемп ажилтын сууц орчин	500	15*10 ⁵	Илрэв/0.01/	Илрээгүй	Илрэв/0.01/	Илрээгүй
2	Л-273	Ахуйн жорлон, хогийн цэг	500	2.2*10 ⁵	Илрэв/0.0001/	Илрээгүй	Илрэв/0.001/	Илрээгүй
Шинжилгээний аргын стандарт				MNS 6341:2012	MNS 5367:2004	MNS 5367:2005	MNS 6341:2012	MNS 6341:2012
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 3297:1991/				Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 25 г-д
Чанарын шинжилгээг хийсэн: ХАНЛАБ лаборатори Д.Пүрэвсүрэн (боловсруулалт хийгдсэн)								

Хүснэгт 45. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-4

Хөрсний зүсэлт: Байгалийн фон	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, Лицензийн талбайн гаднах эрүүл хөрстэй талбай
	Координат: ХӨ 49 ⁰ 26'31.78" ЗУ 113 ⁰ 25'27.24"
	Газрын гадарга: Тэгш тал газар, хөндий хотгор
	Бичил гадарга: Тэгш гадарга
	Налуу: 5-20° (градус)
	Гадаргын чулуу: 5-10 мм хэмжээтэй чулуу тархсан
Чулууны бүрхэц %:	15-20 %
Хөрсний эвдрэл:	Олборлолтын үйл ажиллагаанд өртөөгүй хүний хөлөөр эвдрэлд ороогүй талбай.
Эвдрэлийн хэлбэр:	Малын бэлчээр, орон нутгийн зам
Зонхилох ургамал:	Хээрийн хялганат-алаг өвст, гичгэнэ, азаргана, цахилдаг, хазаар өвс, сөд өвс, бусад үетэн ургамлууд
Ургамал бүрхэц:	80%-аас дээш хувьд нь ургамал ургасан
Хөрсний нэр: Хээрийн цайвар хүрэн өнгийн шороон хөрсний хэв	
А үе (0-7 см): Цайвар хүрэн өнгийн хөрс: том хэмжээтэй хэмхдэс чулуу тархаагүй байна. 0-5 см-ийн гүнд үндэсний тархалт дунд зэрэг байна. Карбонатын тархалтгүй, элсэнцэр, бага зэргийн шаварлаг бүтэцтэй. 2-5 мм хэмжээтэй хэмхдэс чулуулаг 10-15% тархсан.	
В үе (7-15 см): Цайвар шаргал өнгөтэй: 2-6 мм хэмжээтэй жижиг сайр чулууны тархсан байх ба, үндэсний тархалтгүй байна. В үе давхаргад нягтшил нэмэгдэх ба өнгөөр бүдэг шилжилттэй байна. Мөн чулуулгийн тархалт нэмэгдэж том хэвхдэст чулуулаг түгээмэл тохиолдоно.	
С үе (15 см-аас их): Цайвар өнгөтэй, самранцар бүтэцтэй, дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, нягтшилаар нэмэгдэнэ. Хэмхдэс чулууны тархалт үргэлжлэх ба үргэлжилсэн хайрган үетэй.	

Хүснэгт 46. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/

№	Лаб №	Дээжний байршил	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ	CO ₂ , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриуд, экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	25/2624	49°26'31.78" 113°25'27.24"	0-20	9.02	0.06	0.114	0.99	2.20	21.5	17.9	3.8	0.8	43

Тайлбар:

Төслийн үйл ажиллагаа явуулаар төлөвлөж буй талбайн байршил орчмоос 500 м орчим зайд байх өмнө үйл ажиллагаа явуулж байгаагүй талбайгаас дээж авч шинжилгээнд хамруулсан болно. Энэ нь ялзмаг шим тэжээлийн агуулга дундаж шим тэжээлийн агууламж өндөр байх ба ургамал ургах орчин сайн бүрдсэн байна. Тухайн талбайн хөрс нь рН-ийн агуулга өндөртэй байх ба карбонатлаг, сул давслагтай, цахилгаан дамжуулах чадвар өндөртэй хөрс байна.

Хүснэгт 47. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	25/2624	49°26'31.78" 113°25'27.24"	0-10	18.4	22.4	17.5	10.0	20.6	11.1	41.7

Тайлбар:

Эрүүл хөрстэй уурхайн байршилаас зайдуу авсан энэхүү хөрсний дээжнээс авч үзэхэд элсэрхэг бүтэцтэй, шаварлагийн агууламж дунд зэргийн тоосорхог агууламж ихтэй талбай байна.


Хүснэгт 48. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лабораторийн дугаар	Дээжний байршил	Агууламж мг/л					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
1	25/2624	49°26'31.78" 113°25'27.24"	28.8	-	32.3	51.1	25.7	22.8
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ			/MNS 5850:2019/					

Тайлбар:

Байгаль орчны хяналтын шинжилгээний ажлын хүрээнд авсан хээрийн судалгааны хүрээнд төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршлын тэр дундаа баяжуулах үйлдвэр орчмын 20 м зайд байрлах хэсгээс хөрсний дээжийг өнгөн хөрснөөс дээж авч шинжлүүлэхэд тухайн газрын хөрсөн бүрхэвчээс ямарваа нэгэн хүнд металлын гаралтай бодис хүлцэх хэмжээнээс давж бохирдоогүй байна.

Хүснэгт 49. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-5

Хөрсний зүсэлт: 5	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, нөхөн сэргээлт хийсэн талбай
	Координат: ХӨ 49°27'58.18" ЗУ 113°25'08.57"
	Газрын гадарга: Тэгшивтэр уулын дэнж
	Бичил гадарга: Замын баруун хэсэг
	Налуу: 5-15° (градус)
	Гадаргын чулуу: 5-10 мм хэмжээтэй чулуу тархсан
Чулууны бүрхэц %:	15-20 %
Хөрсний эвдрэл:	Техногений нөлөөллөөр зарим хэсгийн талбайн нөхөн сэргээлтийн талбай нь эвдрэлд орсон
Эвдрэлийн хэлбэр:	Техноген
Зонхилох ургамал:	Хээрийн хялгана, дааган сүүл
Ургамал бүрхэц:	Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил орчимдоо ургамлын тархалт сийрэг, цөөн төрөл, зүйлийн ургамал ургасан
Хөрсний нэр: Хээрийн мараалаг цайвар хүрэн өнгийн хөрсний хэв	
А үе (0-10 см): Цайвар шаргал өнгийн шороон хөрс- сулавтар шаварлагтай, ихэнх бүрэлдэхүүн нь хар шороон хөрс эзлэх шинжтэй, дараагийн үед шилжихдээ өнгөөр үл ялимаг ялгарна. Үндэсний тархалт энэ үед гүехэн байх ба 10 см хүртэлх гүнд үргэлжилж байна.	

Хүснэгт 50. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн /MNS 3310:1991/

№	Лаб №	Дээжний байршил	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ	СО ₂ , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	25/2622	49°26'31.78" 113°25'27.24"	0-20	8.05	0.02	0.048	0.00	3.52	28.0	21.4	6.6	1.0	51

Тайлбар:

Төслийн үйл ажиллагаа явуулаар төлөвлөж буй талбайн байршил орчимд байх өмнө нь нөхөн сэргээлт хийж байсан талбайгаас дээж авч шинжилгээнд хамруулсан болно. Энэ нь ялзмаг шим тэжээлийн агуулга бага түвшний шимт хөрс буюу үржил шимт үеийн зузаан бага байсан ба тухайн хөрс үл ялиг давсжилттай цахилгаан дамжуулах чадвар сулавтар, карбонатын агууламж өндөр гарсан байна.

Хүснэгт 51. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	25/2622	49°26'31.78" 113°25'27.24"	0-10	43.1	22.5	9.1	5.9	13.3	6.1	25.3

Тайлбар:

Хөрсний овоолго орчимд хадгалж буй талбай нь тоос болон шаврын агууламж багавтар элс хайрганы агууламж өндөр хөрс байна.

Хүснэгт 52. Хөрсний механик бүрэлдхүүн /MNS 6824:2020/

№	Лабораторийн дугаар	Дээжний байршил	Агууламж мг/л					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/
1	25/2622	49°26'31.78" 113°25'27.24"	32.6	-	17.5	65.9	12.1	11.2
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ			/MNS 5850:2019/					

Тайлбар:

Байгаль орчны хяналтын шинжилгээний ажлын хүрээнд авсан хээрийн судалгааны хүрээнд төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршлын тэр дундаа баяжуулах үйлдвэр орчмын 20 м зайд байрлах хэсгээс хөрсний дээжийг өнгөн хөрснөөс дээж авч шинжлүүлэхэд тухайн газрын хөрсөн бүрхэвчээс ямарваа нэгэн хүнд металлын гаралтай бодис хүлцэх хэмжээнээс давж бохирдоогүй байна.

Хүснэгт 53. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-6

Хөрсний зүсэлт: 6	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, Кемп
	Координат: ХӨ 49°25'50.97" ЗУ 113°25'48.99"
	Газрын гадарга: Тэгшивтэр уулын дэнж
	Бичил гадарга: Хотхоны зориулалтаар ашиглаж буй тэгш газар
	Налуу: 0-10° (градус)
	Гадаргын чулуу: 5-10 мм хэмжээтэй чулуу тархсан
Чулууны бүрхэц %:	15-20 %
Хөрсний эвдрэл:	Техногений нөлөөллөөр зарим хэсгийн байгалийн хэвэнд нь авч үлдсэн, явган хүний зам, машины зогсоол
Эвдрэлийн хэлбэр:	Техноген, хүн
Зонхилох ургамал:	Хээрийн хялгана, дааган сүүл
Ургамал бүрхэц:	Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил орчимдоо ургамлын тархалт сийрэг, цөөн төрөл, зүйлийн ургамал ургасан
Хөрсний нэр: Хээрийн хүрэн өнгийн хөрсний хэв	
А үе (0-10 см): Үржил шимт давхаргын гүн нь 10 см ба түүнээс бага 9 см орчмоос үндэсний тархалт зогсож, хэмхдэст чулуулаг тархана. Бага зэргийн шаварлаг бүтэцтэй, тоосорхог агууламж өндөртэй чулуулаг бага байна.	

Хүснэгт 54. Хөрсний хээрийн судалгаа, зүсэлт-7

Хөрсний зүсэлт: 7	
	Огноо: 2026-03-31
	Байршил: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, Цагаан чулуут худаг, MV-000400 тусгай зөвшөөрлийн талбай, Кемп
	Координат: ХӨ 49°25'50.97" ЗУ 113°25'48.99"
	Газрын гадарга: Тэгшивтэр уулын дэнж
	Бичил гадарга: Хотхоны зориулалтаар ашиглаж буй тэгш газар
	Налуу: 0-10° (градус)
	Гадаргын чулуу: 5-10 мм хэмжээтэй чулуу тархсан

Чулууны бүрхэц %:	15-20 %
Хөрсний эвдрэл:	Техногений нөлөөллөөр зарим хэсгийн байгалийн хэвэнд нь авч үлдсэн, явган хүний зам, машины зогсоол
Эвдрэлийн хэлбэр:	Техноген, хүн
Зонхилох ургамал:	Хээрийн хялгана, дааган сүүл
Ургамал бүрхэц:	Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил орчимдоо ургамлын тархалт сийрэг, цөөн төрөл, зүйлийн ургамал ургасан
Хөрсний нэр: Хээрийн хүрэн өнгийн хөрсний хэв	
А үе (0-10 см): Үржил шимт давхаргын гүн нь 10 см ба түүнээс бага 9 см орчмоос үндэсний тархалт зогсож, хэмхдэст чулуулаг тархана. Бага зэргийн шаварлаг бүтэцтэй, тоосорхог агууламж өндөртэй чулуулаг бага байна.	

Тайлбар:

Төслийн үйл ажилагаа явуулах явцад кемпийн зориулалттай ашиглахаар төлөвлөж буй тухайн газар нь өмнө нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан компанийн кемп-д кемплэхээр болсон ба тухайн кемпийн одоогийн байгаа бохирдол хэр байх дараагийн шатанд тухайн төслөөс ямар бохирдол үүсэхийг магадлах, харьцуулалт хийх зорилгоор тухайн газраас дээж авч нарийвчилж дүн шинжилгээ гаргадаг ХАНЛАБ лабораторит шинжилгээ өгч шинжлүүлээ. Мөн ерөнхий үнэлгээний хөрсний бүлгийн шинжилгээ болон зүсэлтийн мэдээг бүхэлд нь хуулж орууллаа.

2.9. Ургамлын төрөл зүйлийн судалгаа

Хүснэгт 55. Байгалийн фон буюу эрүүл талбай, ургамлын бичиглэл судалгаа-1

		Зурган дээр хуурай өвстэй, тал хээрийн экосистемд ургадаг ургамлууд харагдаж байна. Гэвч зөвхөн зурагт үндэслэн яг таг зүйл тодорхойлох боломж хязгаарлагдмал байдаг. Гэсэн ч ургамлын гадаад хэлбэр, орчны онцлогийг харгалзан дараах ургамлууд байх магадлалтай
Д/д	Латин нэр	Монгол нэр
1	<i>Stipa krylovii</i>	Крыловын хялгана
2	<i>Stipa gobica</i>	Говийн хялгана
3	<i>Agropyron cristatum</i>	Саман ерхөг
4	<i>Cleistogenes squarrosa</i>	Дэрвээн хазаар өвс
5	<i>Atragene sibirica</i>	Сибирь чөдөр өвс

6	<i>Artemisia commutata</i>	Хурган шарилж
7	<i>Artemisia frigida</i>	Цайвар шарилж /Торгон шарилж/
8	<i>Heteropappus hispidus</i>	Арзгар согсоот

Илүү давамгайлж буй ургамал нь бутгай өвс (*Stipa krylovii*). Ургамлын бүрхэц сийрэг байна. Энэ нь хүний зохисгүй харилцаа, олборлолтын нөлөөгөөр доройтсон байж болзошгүй. Хуурайшсан олон наст үетэн давамгайлсан байна.

Энэ нь нөхөн сэргээгдэх боломжтой боловч удаан хугацаа шаардах, бэлчээрийн дарамт эсвэл хүний үйл ажиллагааны улмаас өөрчлөгдсөн экосистемийн шинж юм.

Stipa krylovii (бутгай өвс), *Cleistogenes songorica* (хялгана) зэрэг хээрийн бүсэд зонхилон ургадаг, хуурайшилт болон доройтолд тэсвэртэй ургамлууд давамгайлж байгаа нь ажиглагдав. Ургамлын бүрхэц сийрэг бөгөөд хөрсний ил хэсэг харьцангуй өндөр хувийг эзэлж байгаа нь экологийн доройтлын түвшин дунд болон түүнээс дээш байж болзошгүйг илтгэнэ.

Хүснэгт 56. Нөхөн сэргээлт хийгдсэн талбай, ургамлын бичиглэл, судалгаа-2

		<p>Төслийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн талбайн байршил орчимд өмнө ашиглалт явсны дараа нөхөн сэргээлт хийсэн талбайн байршилд хийсэн ургамлын судалгаагаар тухайн талбайд 3 зүйлийн ургамал ургасан байв. Энэхүү ургамлын тархалт нь маш сийрэг нүдний тусгац бүрхэцд тусах ургамлын тархалтын хувь ойролцоогоор 30% болон түүнээс бага байхаар тархалттай ургасан байв.</p>
Д/д	Латин нэр	Монгол нэр
1	<i>Stipa krylovii</i>	Крыловын хялгана
2	<i>Stipa gobica</i>	Говийн хялгана
3	<i>Agropyron cristatum</i>	Саман ерхөг

Хүснэгт 57. Ургамлын бичиглэл судалгаа-3

		<p>Төслийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн талбайн байршил орчимд шимт хөрсний овоолго орчимд хийсэн ургамлын судалгаагаар тухайн талбайд 2 зүйлийн ургамал ургасан байв. Энэхүү ургамлын тархалт нь маш сийрэг нүдний тусгац бүрхэцд тусах ургамлын тархалтын хувь ойролцоогоор 20% болон түүнээс бага байхаар тархалттай ургасан байв.</p>
Д/д	Латин нэр	Монгол нэр
1	<i>Stipa krylovii</i>	Крыловын хялгана
2	<i>Agropyron cristatum</i>	Саман ерхөг



2.10. Төслийн талбайн байршилд хийгдсэн амьтны тархалт судалгаа

“Дамбат” ХХК-ийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй тус талбайн байршилд хийсэн амьтны төрөл зүйлийн судалгаа нь тухайн орчинд үйл ажиллагаа явуулж буй өөр уул уурхайн төслийн байгаль орчны мэргэжилтэний хийсэн судалгаанд тулгуурлан энэхүү бүлгийг бэлтгэлээ. Тэгвэл дараах амьтад төслийн талбайн байршил орчимд бүртгэгдсэн байна.

Дараах судалгааг судлаачийн зөвшөөрөлтэйгөөр хуулж авсан болно².

² “Монголиан метал ложистик” ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны биелэлтийн тайлан Байгаль орчны мэргэжилтэн М.Сүбээдэй

Хүснэгт 58. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-1



Цагаан зээр-Procapra gutturosa

Цагаан зээрийн цөөн тоотой сүрэгтэй лицензийн талбайгаас 15-20 км зайд улз голын эрэг дагуу бэлчид байгаатай таарав. Энэ нь 2022 оны 08-р сарын 07-ны өдрийн 18 цагийн орчимд байсан бөгөөд харин лицензийн талбайтай ойролцоо 5 км газарт бүртгэгдээгүй байна.

Хүснэгт 59. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-2



Бор туулай-Lepus arcticus

Хамгийн олон тоогоор тохиолдор амьтан. Энэхүү туулай нь кемпийн хашаанд уурхайн ойролцоо, зам гээд бүхий л газар тохиолддог.

2022 оны 08 сарын 15 нд кемпийн хашаанд, тус сарын 19-нд уурхайн ажилчдын мод тарьсан талбайнд баруун урд хэсгийн нуурын ойролцоо тохиолдсон болно.

Хүснэгт 60. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-3



Өмхий хүрэн- Mephitidae spilogale

Кемпийн байрлалд 6 сард 1 удаа орж ирсэн байгаатай тохиолдсон бөгөөд энэхүү амьтан нь нутгийн оршин суугчдаас асуухад төдийлөн олон тоогоор ажиглагддаггүй амьтдын тоонд орж байгаа.

Хүснэгт 61. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-4



Хун-Anserinae Cygnus

Энэхүү амьтан нь уурхайн 2010 оноос өмнө олборлолтын шатанд үүссэн бөгөөд нийт тоо нь 11 орчим байгаа. 2024 оны 07-р сарын 09-ний өдөр 9 толгой бүртгэгдсэн

Хүснэгт 62. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-5



Бор нугас-Anas strepera

Лицензийн талбайн урьд байрлах Германы уурхай гэж нэрлэгдэх газрын үүсмэл нууранд цөөн тоогоор тохиолдсон. 2022 оны 08 сарын 08 өдөр, 15 цагийн үед

Хүснэгт 63. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-6



Тагтаа- Columbidae

Уурхайн ойролцоо маш цөөн тоогоор харагддаг бөгөөд төв суурин газрыг бодвол тоо толгой маш цөөн.

Хүснэгт 64. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-7



Хэрээ- *Corvidae corvus*

Уурхайн кемп болон баяжуулах орчмоор цөөн тоогоор тохиолдоно. Тухайн жигүүртэн нь төв суурин газрыг түшиглэн амьдрах амьтан бөгөөд хээрийн бүсэд маш цөөн тоо толгойгоор бүртгэгддэг амьтан болно.


Хүснэгт 65. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-8



Тагтаа- *Columbidae*

Уурхайн ойролцоо маш цөөн тоогоор харагддаг бөгөөд төв суурин газрыг бодвол тоо толгой маш цөөн.

Хүснэгт 66. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-9



Могой жараахай- *Barbatula toni (Shireet)*

Энэхүү загасны төрөл зүйл нь бидний хэлж сурснаар Германы уурхайн нууранд харагдсан нь 3 ш байсан ба тухайн талбай нь замагшиж загас үржих боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 67. Амьтны төрөл зүйлийн бичиглэл-10



Нэр нь үл мэдэгдэх загасны жараахай

Энэхүү загасны төрөл зүйл нь бидний хэлж сурснаар Германы уурхайн нууранд харагдсан нь 3 ш байсан ба тухайн талбай нь замагшиж загас үржих боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.11. Тусгай хамгаалалттай газар

Дорнод аймгийн Баяндун сумын “Дамбат” ХХК-ний Цагаан чулуут нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй орд төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газрын бүсчилд хамааралгүй болно.

2.12. Палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлын дүгнэлт

Тус ашиглалтын талбайд давхраат хурдсаас дээд протерозойн Хайчингол формацын хувирмал хурдас чулуулаг, дөрөвдөгчийн сэвсгэр хурдас, гүний интрузив чулуулгаас палеопротерозой интрузив, сизурал Улзгол бүрдэл тархсан байна.

Өмнөх геологийн судалгаагаар дээд протерозойн Хайчингол формацын хувирмал хурдас чулуулгаас палеонтологийн үлдэгдэл олдож байгаагүй бөгөөд бидний хийсэн палеонтологийн хайгуул тандан судалгаагаар тус "Цагаан чулуут худаг" нэртэй MV- 000400 тоот (103.47га) талбайгаас палеонтологийн ямар нэг үлдэгдэл илрээгүй болно.

2.13. Нийгэм эдийн засаг Дорнод аймгийн Баяндун сум

Баяндун сум нь Хүн ам сийрэг суурьших бөгөөд нутгийн зонхилох иргэд нь буриад, мөн халх, үзэмчин, барга ястан нутаглана. Нутгийн иргэд мал аж ахуй эрхэлнэ.

Засаг захиргааны харьяаллаар Дорнод аймгийн Баяндун сумын нутагт хамаарах ба сумын төвөөс хойш 30-32 км зайд байрлана. Сумын төвд эмнэлэг, сургууль, цэцэрлэг, цахилгаан холбоо /үүрэн телефон ордноос чөлөөтэй холбогдоно/, ахуйн үйлчилгээний олон газрууд, шатахуун түгээх станцууд ажиллана.

Зам харилцаа, эрчим хүчний хангамж сайтай. Жилийн аль ч улиралд аймаг, сумуудын хооронд ашиглах боломжтой сайжруулсан шороон замтай. Мөн талбайн өмнө талаар Чойбалсан-Ульханы сайжруулсан шороон зам холгүй өнгөрнө. Аймгийн төв, Улаанбаатар хотыг холбосон шуудан, тээвэр тогтмол үйлчилнэ.

Дорнод аймгийн Баяндун сумын “Дамбат” ХХК-ний Цагаан чулуут нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй орд төслийн нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшинг авч үзлээ.

2.13.1. Дорнод аймгийн Баяндун сум

Баяндун сум нь Хүн ам сийрэг суурьших бөгөөд нутгийн зонхилох иргэд нь буриад, мөн халх, үзэмчин, барга ястан нутаглана. Нутгийн иргэд мал аж ахуй эрхэлнэ.

Засаг захиргааны харьяаллаар Дорнод аймгийн Баяндун сумын нутагт хамаарах ба сумын төвөөс хойш 30-32 км зайд байрлана. Сумын төвд эмнэлэг, сургууль, цэцэрлэг, цахилгаан холбоо /үүрэн телефон ордноос чөлөөтэй холбогдоно/, ахуйн үйлчилгээний олон газрууд, шатахуун түгээх станцууд ажиллана.

Зам харилцаа, эрчим хүчний хангамж сайтай. Жилийн аль ч улиралд аймаг, сумуудын хооронд ашиглах боломжтой сайжруулсан шороон замтай. Мөн талбайн өмнө талаар Чойбалсан-Ульханы сайжруулсан шороон зам холгүй өнгөрнө. Аймгийн төв, Улаанбаатар хотыг холбосон шуудан, тээвэр тогтмол үйлчилнэ.

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	279077,2	96.05
Ойн сан бүхий газар	159	0.06
Усан сан бүхий газар	368	0.13
Тусгай хэрэгцээний газар	4960	1.71
Тосгон, суурингийн газар	2677,5	0.92
Дэд бүтцийн газар	3285,3	1.13

Малын бүтэц: Сумын хэмжээнд 75361 толгой малтайгаас тэмээ 163 буюу 0.22 хувь, адуу 7394 буюу 9.81 хувь, үхэр 2827 буюу 3.75 хувь, хонь 39272 буюу 52.11 хувь, ямаа 25705 буюу 34.11 хувь байна.

Зам тээвэр харилцаа хот байгуулалт:

Баяндун сум нь зам тээврийн дэд бүтцийн хувьд аймгийн бусад сумдаас харьцангуй

бага. Баяндун сумын төв нь Засаг захиргаа -дэд бүтэц-үйлдвэрлэл, үйлчилгээний үүрэг давамгайлсан тосгон юм. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2015 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн боловсруулж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. Сумын төвийн суурьшлын бүс хүн амын механик өсөлтөөс шалтгаалан сүүлийн 5 жилийн хугацаанд 28 га-аар нэмэгдсэн. Сумын нутаг дэвсгэр нь 623705 га, үүнээс бэлчээрийн газар 478411.5 га, хадлангийн талбай 33523 га, тариалангийн газар 32.4 га байна. Төв нь УБ хотоос 665 км, /Чойбалсан хотоос 176 км алслагдсан Наранбулаг суурин. Сум 3000 хүн ам, 800 өрхтэй бөгөөд засаг захиргааны 4 багт харьяалагдаж байна. Нийт 130000 малтай, үүнээс тэмээ 160, адуу 8500, үхэр 12500, хонь 73000, ямаа 35000 толгой байна.

Боловсрол:

Баяндун сумын 12 жилийн дунд сургууль 281 суралцагчтайгаар 72 дахь хичээлийн жилдээ сургалт хүмүүжлийн ажлаа явуулж байна. Мэргэжлийн багшаар 100 хувь хангагдсан ба 80 хувь нь дээд боловсролтой, 40 хувь нь мэргэжлийн зэрэгтэй багш нар ажиллаж байна. Сумын 313 хүүхэд сургуульд хамрагдахаас 281 суралцагч сургуульд суралцаж хамран сургалт 89,8 хувь нь шалтгаангүйгээр сургууль завсардсан хүүхэд байхгүй. 6 настай 24 хүүхэд суралцахаас 24 нь суралцаж хамран сургалт 100 хувь байна. Нийт 10 бүлэгт 251 суралцагч суралцаж анги дүүргэлт 25 сурагчтай байна. Дотуур байранд 16 сурагч ая тухтай амьдарч байна. Үдийн цайнд 164 сурагч хамрагдаж байна.

Баян сумын цахилгаан, дулаан хангамж:

Сумын төв нь төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1992 онд баригдсан 35/6000квт-ийн дэд станцтай. Сумын төвд төвлөрсөн уурын зуух байхгүй.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ

Дорнод аймгийн Баяндун сумын “Дамбат” ХХК-ний Цагаан чулуут нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй орд төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар байгалийн бүрэлдэхүүн хэсэг болох ус, хөрс, агаар, амьтаны аймагт нөлөөлөх байдлыг тодорхойлов. Нарийвчилсан үнэлгээнд төслийн үйл ажиллагаанаас нь байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх хүчин зүйлс, нөлөөллийн цар хүрээ, эрчим, үргэлжлэх хугацааг нарийвчилан тусгаж урьдчилан сэргийлэх арга хэмжээ, заавар, зөвлөмжийг боловсруулна.

3.1. Газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсэх

- Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх
- Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон усаар угаагдаж элэгдэх
- Хөрс эвдэрч физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, цөлжилт нэмэгдэх
- Хөрс хатуу хог хаягдлаар бохирдох
- Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрс, усанд нэвчиж бохирдуулах

3.2. Төслөөс ургамлан нөмрөгт учруулах нөлөөлөл

Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор, хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл, хажуу, нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь олборлолтын үйл ажиллагаа, дотоод болон тээвэрлэлтээс үүсэх тоосонцор, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх ухааш, гадаад овоолго болон бусад объектын нөлөөгөөр ургамлан нөмрөг устах буюу доройтолд орно. Иймд нарийвчилсан үнэлгээгээр шууд болон шууд бус нөлөөллийг нарийн тодорхойлж урьдчилан арга хэмжээ, заавар, зөвлөмжийг дэлгэрэнгүй тусгах шаардлагатай.

3.3. Төслөөс ус орчинд учруулах нөлөөлөл

